

БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.04.23 №16 (10693)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын эрхэм генералууд аа!
Эдүгээгээс 76 жилийн тэртээ буурал Европт дэлхийн их дайны гал ид дүрэлзэн, Дорно зүгт милитаристуудын зэр зэвсэг хангинан түрэмгийллийн аюул нүүрлэж байсан хүнд бэрх цаг үед Монгол төр 11 хүнд генерал хэмээх цол анх олгосон нь цэргийн байгуулалтын нэгэн шинэ үе эхэлж буйг нотолсон түүхэн шийдвэр байсан юм.
Түүхэн энэ ойг тохиолдуулан эрхэм Танд Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувиасаа баярын мэндийг хүргэж, сайн сайхны ерөөл дэвшүүлье!

Монгол Ардын Хувьсгалт Цэрэг, Монголын Ардын Арми, Монгол Улсын Зэвсэгт хүчний генерал, офицерууд 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайн, баруун хил дээрх зэвсэгт мөргөлдөөн, дайны дараах энхийн бүтээн байгуулалт, "хүйтэн дайн"-ы жилүүдийн өргөтгөн зохион байгуулалт, Монгол Улсын Зэвсэгт хүчний байгуулалтыг аюулгүй байдлын шинэ орчин хийгээд Монгол Улсад хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлоох зорилгод нийцүүлэн шинэчлэх, Төрийн цэргийн байгууллагын алба хаагчдыг НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах зэрэг зохион байгуулах авьяас, бие сэтгэлийн зориг, тэнхээ, мэргэжлийн ур чадвар шаардсан их үйлсэд төр, ард түмнийхээ итгэл найдварыг нэр төртэй биелүүлсэн юм.

Эрхэм генерал Та Монголын Ардын Арми, Монгол Улсын Зэвсэгт хүчний байгуулалтын эгзэгтэй цаг үед өргөтгөн зохион байгуулах, цомхотгох, шинэ бүтцэд шилжүүлэх зэрэг нөр их ажил, онцгой хариуцлагатай үйл хэргийн ачааны хүндийг үүрч, Зэвсэгт хүчний гол цөм, ноён нурууг нь хадгалж, хамгаалж, хөгжүүлж бэхжүүлсэн гавьяат үйлсэтэн билээ.

Генерал хүн бол Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүний эр зориг, эрдэм чадвар, хүний жудаг, ёс зүйн үлгэрлэн дуурайх жишээ, дагаж омогших туг нь юм. Энэ үүрэг хариуцлагаа гүнээ ойлгож, ухамсарт бүхий л амьдралаа цэрэг, эх орныхоо төлөө зориулж ирсэн, өдгөө албаа хашиж буй болон чөлөөнд гарсан нийт генералууддаа их амжилт, урт нас, удаан жаргалын ерөөл дэвшүүлье.

Монгол цэргийн сүлд хийморь, яруу алдар бадартугай!
**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Н.ЭНХБОЛД**

Монгол Улсынхаа эрх чөлөө, тусгаар тогтнол, улс орныхоо бүтээн байгуулалт, хөгжил дэвшил, аюулгүй байдлын төлөө бие сэтгэлээ зориулж, эх орноо батлан хамгаалах хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргээ амжилттай биелүүлж яваа Төрийн цэргийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудад алба хааж байгаа болон бэлтгэл, чөлөөнд буй генералууд Та бүхэндээ "Монгол генералын өдөр"-ийн баярын мэндийг Монгол Улсын ЗХЖШ-ын даргын зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувиасаа өргөн дэвшүүлье!

Өдгөөгөөс 76 жилийн өмнө буюу 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор цэргийн гарамгай 11 зүтгэлтэнд "ГЕНЕРАЛ" хэмээх цэргийн дээд цолыг анх удаа олгосноос хойш жил бүрийн энэ өдрийг алтан мөрдэстнүүдийн өдөр болгон тэмдэглэж ирсэн нь эх орныхоо тусгаар тогтнол, халдашгүй бүрэн эрх, аюулгүй байдлын төлөө зүтгэсэн Та бүхнээр бахархах, хүндэтгэн дээдлэх, дайчин уламжлалыг тань үр хойчдоо өвлүүлэх, монгол бахархлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэгддэг билээ.

Генерал цолтнууд Та бүхэн удирдан зохион байгуулах авьяас билиг, цэргийн хэргийн өргөн мэдлэг, чадвар, хүний мөс, ноён нуруу, үлгэрлэл, манлайллаараа тэргүүлэгчид бөгөөд төр, түмнийхээ энэ их хүндэтгэлийг нэр төртэй дааж яваа цэрэг эрс гэдгийг баярын энэ өдөр онцлон тэмдэглэх учиртай билээ.

Өнөөдөр Та бүхний залгамж халаа болсон цэрэг дайчид дэлхийн халуун цэгт ур чадвараараа гайхагдан, улс орныхоо бүтээн байгуулалтад хөдөлмөрч, бүтээлчээрээ шалгаран тодорч байгаа бол энх цагийн эгэл баатрууд маань аюул осол, хэрэг зөрчлөөс ард түмнээ хамгаалах, авран тэтгэх ариун үйлсээ нэр төртэй гүйцэтгэж байгааг дуулгахдаа баяртай байна.

Эх орон, ард түмнээ батлан хамгаалагчдын оргил нь болон гялалзсан алтан мөрдэст эрхэм генералууд Та бүхэндээ урт насалж, удаан жаргахыг хүсэн ерөөе.

**МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ**



**АНХАН ШАТНЫ
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХУРАЛ
ЦАХИМААР ЯВАГДЛАА**

"Аравт-2020" олон улсын морин цэргийн уралдааны анхан шатны төлөвлөлтийн хурал 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр цахимар явагдлаа. Цахим хуралд ЗХЖШ-ын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар, ЗХЖШ-ын Сургалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ, ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Цэрэг, агаарын цэргийн атташе, хурандаа П.Г.Анисов нар оролцов. Хурлын эхэнд хошууч генерал Ж.Бадамбазар цахим хуралд оролцогч орнуудад талархал илэрхийлээд "Аравт-2020" олон улсын морин цэргийн уралдааны зохион байгуулалтын талаар мэдээлэл хүргэсэн бол хурандаа Д.Цог-Эрдэнэ уралдааны зааварт орсон өөрчлөлт, шүүлтийн талаар ярилаа. Энэ үеэр оролцогч талуудаас уралдаанд өөрсдийн мориор оролцож болох тухай, үүнийг шийдвэрлэх боломж байгаа эсэх, зохион байгуулалтад өөрчлөлт оруулсан эсэх тухай асууж, санал солилцов.



Хурлын төгсгөлд хурандаа Д.ЦОГ-ЭРДЭНЭЭС зарим зүйлийг асууж тодрууллаа.

Цахим хурлын үр дүнгийн талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Хурлаар хоёр гол асуудлыг хэлэлцлээ. Нэгдүгээрт, өнөөдөр дэлхий нийтэд тархаад байгаа шинэ коронавирусийн нөхцөл байдлаас хамаараад "Олон улсын цэргийн наадам"-ын хүрээнд "Аравт-2020" олон улсын морин цэргийн уралдааныг төлөвлөсөн ёсоороо зохион байгуулах, эсэх талаар оролцогч орнуудтайгаа ярилцаж, санал бодлоо солилцсон. Хоёрдугаарт, уралдааны зохион байгуулалт, шүүлт, заавар зэрэгт анхаарах ямар асуудал байгааг нь журмын нөхдөөсөө асууж тодруулсан. Мөн Монгол Улсын талаас дэлхий нийтэд коронавирусийн халдварын тархац хумигдаж, сайхан цаг ирэхэд "Аравт"-ыг зохион байгуулахад бэлэн байх болно гэдгээ ч илэрхийллээ.

Оролцогч орнуудаас ямар санал дэвшүүлж байна вэ?

-Хэд хэдэн асуудлыг тодруулсан. Тэр дундаа уралдаанд өөрсдийнхөө морьтой оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлж, Монгол Улс руу адуугаа нэвтрүүлэхэд эрх зүйн хүрээнд боломж байгаа, эсэх талаар асууж байна. Монгол Улсын Засгийн газраас мал экспортлохыг хориглосон тогтоол гараад удаагүй, хэрэв адуугаа авчирна гэвэл Батлан хамгаалахын сайд, магадгүй Засгийн газрын түвшинд ярилцах шаардлагатай гэдгийг илэрхийлсэн. Гэхдээ Монгол, Орос хоёр улс мөнхийн хөрш орнууд учраас энэ асуудлыг шийдвэрлэх боломж байгаа гэж харж байна.

Дараагийн хурлыг хэзээ зохион байгуулах вэ?

-Цар тахлын хүрээ хумигдаж нөхцөл байдал сайжирвал ирэх 6 дугаар сард хийхээр төлөвлөсөн.

**ХУРАНДАА ГЕНЕРАЛ С.ЛУВСАНГОМБОД
НИЙСЛЭЛЭЭС ОРОН СУУЦ ӨГӨХӨӨР БОЛЖЭЭ**



Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан НАХЯ-ны сайд асан, хурандаа генерал С.Лувсангомбод хандаж эрүүл энх, урт удаан наслахыг ерөөж, Хотын захиргаанаас түүнд 10 дугаар хороололд орон сууц олгох болсон тухай таатай мэдээг дуулгав. Хурандаа генерал С.Лувсангомбо Улаанбаатар хотын захирагч С.Амарсайханд баярлаж талархсанаа илэрхийлэхийн ялдамд түүнийг Хотын дарга болсон цагаас хойш Улаанбаатар хот "угаагүй хот" болсныг онцлон тэмдэглэж, цаашдын ажилд нь өндөр амжилт хүслээ.

Түүнчлэн Элчин сайд Д.Даваа жил бүрийн 4 дүгээр сарын 28-ны өдөр уламжлал болгон тэмдэглэдэг "Монгол генералын өдөр"-ийн өмнө энэхүү сайхан мэдээг дуулгасанд баярласнаа илэрхийлэн Улаанбаатар хотын захирагч С.Амарсайханд ажлын амжилт хүсэв. Мөн удахгүй болох "Монгол генералын өдөр"-ийн баярын мэндийг хурандаа генерал С.Лувсангомбо гуайд дэвшүүллээ гэж Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдын яамнаас мэдээллээ.

**Хурандаа С.Баяр-Очир: ӨВӨЛ, ЗУНЫ ХАГАС ТҮРИЙТЭЙ
ШАР ГУТЛЫГ ХАНГАЛТАД ОРУУЛНА**

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжигч байгууллага бөгөөд материал хангалтын ихэнх хувийг нь дотоодоосоо авч, эх оронч худалдан авалт хийдэг жишгийг тогтоогоод удаж байна. Цэргийн дүрэмт хувцасны хангалтын талаар ЗХЖШ-ын Ар талын газрын Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа С.БАЯР-ОЧИРТОЙ ярилцлаа.

Энэ жил цэргийн дүрэмт хувцасны загварт өөрчлөлт орсон уу? Орсон бол ямар өөрчлөлт орсон бэ?

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 175 дугаар зарлигаар Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийн дүрэмт хувцасны загвар батлагдаж, өдгөө мөрдлөг болгон ажиллаж байна. Жишээлбэл, шинээр албаны хүрэм, хээрийн урт ханцуйтай цамц, хүзүүний ороолт (бор, ногоон өнгө), зангианы хавчаар, малгайн тэмдэг (дээд офицер) гээд таван загвар нэмэгдлээ. Үүнээс гадна албаны саравчтай малгай, дугуй малгай, хээрийн гурван нэр төрлийн хувцас, хэрэглэлийн загварт бага зэрэг өөрчлөлт орж, Агаарын цэргийн командлалын албаны дүрэмт хувцас хөх өнгөтэй болсон зэргийг нэрлэж болно. Мөн өвөл, зуны хагас түрийтэй шар гутлыг хангалтад шинээр оруулахаар ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2019 оны 215 дугаар тогтоолоор хувцасны нормд өөрчлөлт оруулсан.

(Үргэлжлэл нь II нүүрт)



Хурандаа С.Баяр-Очир: ӨВӨЛ, ЗУНЫ ХАГАС ТҮРИЙТЭЙ ШАР ГУТЛЫГ ХАНГАЛТАД ОРУУЛНА

(Түрүүч нь I нүүрт)

Тухайлбал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын бие бүрэлдэхүүний хэргийн зуны хүрэм, өмдний хангалт хоёр жил, удирдлагын байгууллагын цэргийн алба хаагчдынх гурван жилийн нормтой байхаар зохицуулсан. Мөн Батлан хамгаалахын дэд сайдаар ахлуулсан комисс төрийн ёслол, цэргийн ёслол, морьт цэргийн дүрэмт хувцасны загварыг батлуулахаар ажиллаж байна. Хэрэв дэлхий нийтээр тархаад байгаа цар тахлын нөхцөл байдал хумигдаж, үндэсний үйлдвэрлэлүүд бараа бүтээгдэхүүнээ оёод эхэлбэл бид 6 дугаар сараас эхлээд зуны дүрэмт хувцасны хангалтаа хийх төлөвлөгөөтэй байна.

Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн дүрэмт хувцасны хангалт ямар түвшинд байгаа вэ?

-Жил бүр Сангийн яамнаас батлагдсан төсвийн хүрээнд Зэвсэгт хүчний хувцас,

хэрэглэлийн хангалтыг зохион байгуулдаг. Мэдээж батлагдсан төсвөөр хангалтыг 100 хувьд хүргэж чадахгүй байгааг та бүхэн мэднэ. Батлагдсан төсвийн хүрээнд нэгдүгээрт, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид, хоёрдугаарт, шинээр сургууль төгссөн төгсөгч нар, гуравдугаарт, офицер, ахлагч нарын хувцас, хэрэглэл гэсэн дарааллаар хангалтыг зохион байгуулж байна. Энэ нь офицер, ахлагч нарын хувцасны хангалт дутмаг байгаагийн гол шалтгаан юм. Энгийнээр тайлбарлавал, энэ жил хувцасны төсөвт 6,8 тэрбум төгрөг батлагдсан бол хэрэгцээ нь 13,5 тэрбум төгрөг болж байгаа юм. Энэ нь нийт хэрэгцээний ердөө 50 хувь нь батлагдсан гэсэн үг.

Шинээр гаргасан дүрэмт хувцасны хангалтын тухайд. Жишээлбэл, албаны хүрэм ...

-Зургаадугаар сараас Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын бие бүрэлдэхүүнийг албаны хүрмээр хангах ажил эхэлнэ. Энэ нь мэдээж тодорхой

шат дараалалтай.

Агаарын цэргийн командлалын харьяа анги, салбаруудын бие бүрэлдэхүүнийг дүрэмт хувцсаар нь хэзээ хангаж дуусах вэ?

-Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын бие бүрэлдэхүүнийг өөрчлөлт оруулсан хувцас, хэрэглэлээр нь бүрэн хангасан. Харин харьяа анги, салбаруудын тухайд 6 дугаар сараас хангаж эхэлнэ.

Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн албаны хангалтад нэмэлт, өөрчлөлт орсон уу?

-Хувцас, хэрэглэлийн хувьд өөрчлөлт оруулаагүй. Харин ахуйн хэрэглэл, угаалга, цэвэрлэгээний материалын талаар илүү их анхаарч, чанарын шаардлагад нийцсэн бараа материалаар хангахаар ажиллаж байгаа. Ялангуяа шүдний оо, шампунь, гарын саванг онцгой анхаарч байна.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

ТҮРГЭН ОНОШЛУУРУУД ХАНДИВЛАВ



Батлан хамгаалах яамны "Алдар" спорт хорооны хамт олон нэг өдрийн цалин болох 4 сая 400 мянган төгрөгийн үнэ бүхий түргэн оношлууруудыг Цэргийн төв эмнэлэгт хандивлав. Хамт олноо төлөөлөн "Алдар" спорт хорооны дарга, хурандаа Г.Өсөхбаяр Цэргийн төв эмнэлгийн штабын дарга, хурандаа Д.Ганбат нарын албан тушаалтнуудад гардуулан өгсөн юм. Энэ үеэр хурандаа Г.Өсөхбаяр "Цэргийн төв эмнэлгийн эмч, сувилагч, ажилтан алба хаагч та бүхэнд юуны өмнө баярлаж байгаагаа илэрхийлье. Улс оронд хүнд үед тохиолдоход тэргүүн эгнээнд байж, иргэдээ аюулт өвчнөөс хамгаалахад ханцуй шамлан зүтгэж байгаа нь та бүхний хамгийн эрхэм чанар юм. Та бүгдийн энэхүү хичээл зүтгэлд дэм болох, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлах үүднээс "Алдар" спорт хорооны хамт олон бид нэг өдрийн цалингаа хуримтлуулан хамгийн хэрэгтэй байгаа энэхүү түргэн

оношлууруудыг та бүхэнд хүлээлгэн өгч байна. Эх орноо хэмээн зорьж ирсэн иргэдээ цаг алдалгүй оношлоход, та бүхний ажлыг бага ч болов хөнгөвчлөхөд хэрэг болж чадвал бидний зорилго тэр" гэлээ.

Дэлхий нийтэд цар тахлын хэмжээнд хүрч аюулын харанга дэгдээж байгаа шинэ төрлийн коронавирусууд иргэдээ ажилд үнэтэй хувь нэмрээ оруулж, өөрсдийн хүч хөдөлмөр, нөөц бололцоог дайчлан ажиллаж байгаа Цэргийн төв эмнэлгийнхний хувьд 2 дугаар сарын 27-ны өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд урьдчилан сэргийлэх, тусгаарлах байрандаа 320 иргэнийг хүлээн авч тусгаарласан бөгөөд өнөөдрийн байдлаар 104 иргэн тус эмнэлэгт хөл хорионд байгаа аж. Мөн эдгээр иргэдэд тус эмнэлгийн 113 эмч, сувилагч, ажилтан алба хаагчид 21 хоногийн турш тусламж үйлчилгээг үзүүлж байгаа юм.

АМНЫ ХААЛТ ХАНДИВЛАЛАА

Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн Эмэгтэйчүүдийн зөвлөл дэлхийн олон улс орнуудыг хамраад байгаа шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 1000 ширхэг амны хаалт урласнаа Цэргийн төв эмнэлгийнхэнд гардуулан өглөө. Бүсгүйчүүд Цэргийн төв эмнэлгийн хамт олон болон тус эмнэлэгт тусгаарлагдсан иргэдэд зориулж найман хоногийн хугацаанд энэхүү амны хаалтыг

манай ангийн эмэгтэйчүүд өөрсдийн гараар амны хаалтыг урласнаа гардуулж өглөө. Бага ч гэсэн тус дэм болно гэдэгт найдаж байна" гэв.

Цэргийн төв эмнэлгийн Мэдрэлийн клиникийн ахлах эмч, ахмад Н.Золжаргал "Манай цэргийнхэн бидэнд болоод тусгаарлагдсан иргэдэд тусламжийн гараа сунгасаар байгаад бид их баяртай байгаа. Зэвсэгт хүчний Жанжин штаб, БХЯ-ны болон



өбсөн байна. Энэ талаар тус ангийн Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, хошууч Б.Энхжаргал "Иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийн манаанд цаг наргүй зүтгэдэг та бүхэн "COVID-19" вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажилд идэвх санаачилгатай оролцож, онцгой нөхцөлд өөрсдийн амь нас, эрүүл мэндээ үл хайрлан төр, засгаас даалгасан хариуцлагатай үүргийг нэр төртэй гүйцэтгэж байна. Тэрхүү нэр их хөдөлмөрийг тань хүндэтгэж

ЗХЖШ-ын Ахмадын хороо, хилийн чанадад үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчид, тэдний гэр бүл, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн Эмэгтэйчүүдийн зөвлөл, "Цэргийн холбоочид" Төрийн бус байгууллага, ахмадууд, "Алдар" спорт хорооны хамт олон, ЦДБЭЧ-ын ахмадууд гээд олон байгууллага, иргэд тусламж ирүүлж байна" гээд Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн эмэгтэйчүүдэд талархал илэрхийлсэн юм.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙВ

Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2019 онд "Орон нутгийн хамгаалалтын тухай" хууль батлагдан гарсангай холбогдуулан өөрийн орон нутгийн газар зүйн байрлал, төвийн болон хилийн бүсийн онцлог, хүн амын өсөлт, засаг захиргааны нэгжийн хуваарилалт, эдийн засгийн бодит боломжид тулгуурлан "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г боловсруулж батлуулсан. Энэхүү төлөвлөгөөтэй уялдуулан Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргаас 2019 оны 12 дугаар сард дүүргийн "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г боловсруулан Нийслэлийн Засаг даргаар батлуулсан бөгөөд тус төлөвлөгөө нь Монголын Улсын өөрийгөө хамгаалах стратеги, улс орноо батлан хамгаалах үйл хэрэгт бүх нийтийн оролцоог хангахад чиглэгдэж байна. "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г улсын болон цэргийн дайчилгааны төлөвлөгөө, гамшгийн үеийн төлөвлөгөөний



цогц байхаар тодорхойлжээ.

Энэхүү төлөвлөгөөний дагуу дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Ариунтуяа, Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах товчооны дарга Н.Батсүмбэрэл, Засаг даргын орлогч Ж.Лхагвасүрэн, Засаг даргын төсөл хариуцсан орлогч Ж.Чимэдцогцол, ЗДТГ-ын дарга Б.Цэрэн, Цэргийн штабын

дарга, хурандаа Ж.Даваарагчаа, Онцгой байдлын хэлтсийн орлогч, ахмад Б.Амандых, Газар зохион байгуулалтын албаны ахлах мэргэжилтэн Ш.Амартайван нар дүүргийн хилийн цэсээр явж, болзошгүй эрсдэлийн үнэлгээг хийж, ойн сав бүхий газрын ойн байцаагч, хороодын Засаг дарга нарт үүрэг чиглэл өглөө.

Ахмад Н.ЛХАМЖАВ

Сэрэмжлүүлэг мэдээ

МОТОЦИКЛИЙН ОСОЛ БАГАГҮЙ ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА

Улсын хэмжээнд зам тээврийн ослын багагүй хувийг мотоциклийн осол эзэлдэг. Тодруулбал, өнөөдөр улсын хэмжээнд 46900 орчим мотоцикл бүртгэлтэйгээс 90 орчим хувь нь орон нутагт байна. Өнгөрсөн онд улсын хэмжээнд мотоцикл унаж яваад осолдсон 489 тохиолдол бүртгэгдсэнээс 122 иргэн амь насаа алдаж, 237 иргэн хүнд гэмтсэн. Энэ жил ч мөн адил мотоциклтэй холбоотой зам, тээврийн осол буурахгүй байгаа нь жолооч нарын анхаарал, болгоомж сул байгаатай холбоотой юм. Осол, зөрчлийн олонх нь согтуугаар жолоодох, бүрэн бус мотоциклтэй замын хөдөлгөөнд оролцох, үзэгдэх орчин хязгаарлагдмал үед гэрэлтүүлэггүй зорчих, хамгаалалтын малгай хэрэглээгүй зэрэг жолоочийн хариуцлагагүй байдлаас үүдэн гарч байна. Энэхүү зөрчлүүдийг гаргаж байгаа жолооч нарыг Зөрчлийн тухай хуулиар торгодог болохыг дахин сануулъя. Зөрчлийн тухай хуульд хамгаалалтын малгай өмсөөгүй замын хөдөлгөөнд оролцвол 10 мянган төгрөг, баримт бичгийн



зөрчилтэй, "А" ангиллын үнэмлэхгүй замын хөдөлгөөнд оролцвол 200 мянган төгрөгөөр тус тус торгоно. Иймд жолооч та бүхэн техник хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг хангаж, өөрийн амь нас, эд хөрөнгөө хайрлан хамгаалахыг анхааруулж байна.

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны цагдаа зохицуулагч, ахлах ахлагч Н.ПҮРЭВЦОГТ

Редакцын шууданд

234 дүгээр анги

Ангийн бие бүрэлдэхүүн шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрүүдийг даган биелүүлж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам болон Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас ирүүлсэн заавар, зөвлөмж, албан даалгавар, сэрэмжлүүлгийг өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Түүнчлэн "Амны хаалтаа зүүцгээе" аянд нэгдэж харьяа орон нутгийнхаа байгууллагуудтай хамтран иргэдэд энэ чиглэлийн мэдээлэл, сурталчилгааг тогтмол явуулж байна.

Ч.ОЮУНЧИМЭГ

326 дугаар анги

Ангийн офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн албаны түрүүч, байлдагч нар бүлгийн зохион байгуулалтад орж тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор 10 километрийн явган маршийг энэ сарын 15, 16-ны өдрүүдэд зохион

байгууллаа. Цогцолбор маршийн үеэр саадын зурвас, буудлага, байр зүй, ҮОХЗХ, тактик, холбооны цэгүүдийг байгуулан бие бүрэлдэхүүний цэргийн хэргийн дадлагыг нэмэгдүүлээ. Мөн "Дэлхийн номын өдөр" болон "Зохиолчдын эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан ангийн номын сангийн зөвлөлөөс салбаруудыг номын булантай болгох зорилгоор зургаан нэр төрлийн 130 ширхэг номыг хандивлав. 2020 оны нэгдүгээр улирлын идэвхтэн уншигчар механик жолооч, ахлагч Д.Содном, байлдагч М.Лхамсүрэн нар шалгарлаа.

Ахмад Э.ГАНБАЯР

337 дугаар анги

Цэргийн төв эмнэлгийн томилгоот эмч нарын баг энэ сарын 17, 20-ны өдрүүдэд тус ангийн байрлалд нэгдсэн үзлэг, шинжилгээг явуулж бие бүрэлдэхүүн бүрэн хамрагдлаа.

Дэслэгч Д.ЭРДЭНЭСУВД

124 дүгээр ангийн 148 дугаар салбар

Өмнөговь аймгийн Засаг дарга



Н.Наранбаатар Зэвсэгт хүчний 148 дугаар салбарын үйл ажиллагааг дэмжин авто машин гардуулан өглөө. Мөн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын онцгой комиссоос гаргасан уриалгыг дэмжиж аймгийн онцгой комисст 700 мянган төгрөгийг хандивлалаа.

124 дүгээр ангийн 143 дугаар салбар

Зэвсэгт хүчний 143 дугаар тусгай салбар түүхт 50 жилийн ойн хүрээнд 50 бүтээлч ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Уг ажлын хүрээнд соёл хүмүүжлийн танхим, офицеруудын өрөө, амралтын пост, холбооны өрөө, спорт заалыг засварлаж ажиллах таатай орчныг бүрдүүллээ. Мөн "Архигүй амар тайван амьдралын төлөө хамтдаа" уриалгыг дэвшүүлэн Баянговь сумын цагдаагийн хэсэг, албан байгууллагуудтай хамтран сум, орон нутгийн төрийн албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль, дүрэм, заавар, өдөр тутмын тушаалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Мөн "COVID-19" халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссоос гаргасан уриалгын хүрээнд салбарын бие бүрэлдэхүүнийг амны хаалтаар хангаж, халуун аарцаар үйлчилж байна.

Хошууч Б.МӨНГӨНЗУЛ

ИХ ГОВИЙН ГАРНИЗОНЫХНЫ АЖИЛ ҮЙЛС ӨӨДӨӨ БАЙНА

Зэвсэгт хүчний 336 дугаар анги нь Цэргийн яамны сайд, Хувьсгалт цэргийн зөвлөлийн тэргүүлэгч, Бүх цэргийн жанжны 1932 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар 6 дугаар морьт дивиз нэртэйгээр анх байгуулагдсан түүхтэй. 1934 онд жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит болж, 1939 онд Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан бөгөөд 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд цохилтын гол чиглэлд үүрэг гүйцэтгэсэн дайчин түүхтэй анги юм. Мөн "Хэрлэн-73", "Говь-77", "Найрамдал-79" зэрэг тухайн үедээ Ази тивийнхээ хэмжээнд томоохонд тооцогдох хээрийн сургуульд амжилттай оролцож байжээ. Мөн ОХУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан "Сэлэнгэ-2017" хээрийн сургуульд үүргээ амжилттай гүйцэтгэсэн.



Хурандаа А.БОЛДБААТАР

эцэг, эхэд нь цалинтай чөлөө олгох зэрэг ажлыг санаачлан орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд бас уриалга хүргүүлсэн. Энэ нь ч иргэдийн талархлыг хүлээсэн ажил болсонд бид бүхэн баяртай байгаа.

Түүнчлэн бие бүрэлдэхүүнээс төмөр замын бүтээн байгуулалтын ажил болон энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд гэр бүлийн хүнийг нь ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлсээр ирсэн. Гадаад, дотоодын цэргийн академи, сургууль, дамжаануудад боломжийн хэрээр суралцуулдаг. Харин үлдсэн бие бүрэлдэхүүн маань тэднийхээ ар талыг дааж байгаа нь хамт олныхоо эрэлт хэрэгцээг хангаж, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэж байгаагийн нэг илрэл юм. Үүнээс гадна агуулахын зориулалтаар ашиглаж байсан хоёр давхар барилгыг бүрэн засварлан төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцож буй "Монголын төмөр зам", "Таван толгой төмөр зам" компаниудын ажилтнуудад хүлээлгэж өгсөн нь тэдний ая тухтай орчинд ажиллах нөхцөлийг нь бүрдүүлсэн гол ажил болсон. Түүнчлэн тус ангид байрлан бүтээн байгуулалтын ажилд үүрэг гүйцэтгэж байгаа зарим анги, байгууллагын алба хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөлийг нь бүрдүүлэх, бүтээн байгуулалтын ажлыг шалгах болон ажиллахаар томилогдсон бүрэлдэхүүнийг тээвэрлэх, байрлуулах, хооллох, ангиудын техник, сэлбэг, хүнс, бараа материалуудыг хадгалж, хамгаалах, усаар хангах зэргээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна" хэмээн хэрэгжүүлж буй гол ажлуудаа онцолсон.

Штабын дарга, дэд хурандаа Н.Батсайхан "2019 оны сургуулийн жилд Зэвсэгт хүчний хэмжээнд зохиогдсон уралдаан, тэмцээнүүдэд амжилттай оролцсон. Жишээлбэл, "Цэрэгжлийн буудлага"-ын тэмцээнд



Дэд хурандаа Н.БАТСАЙХАН

оролцож алтан медаль, шилжин явах цомоо эргүүлэн авсан бөгөөд хошууч Я.Амартүвшин автоматын буудлагын төрөлд 99 оноогоор амжилтаа давтаж, ахмад Д.Жаргалсайхан гар бууны хурдан буудлагын төрөлд 112 оноо авч рекорд тогтоосон. Ингэснээр 20 гаруй жилийн өмнөх амжилтаа бататгаж, бас ахиулсан гэж болно. Мөн Оны мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээнд багаараа гурав, зуны таван төрөлтийн тэмцээнд багаараа тав, олт таталтын тэмцээний эмэгтэйчүүдийн төрөлд тавдугаар байрыг тус тус эзэлсэн бөгөөд сүүлийн жилүүдэд Зэвсэгт хүчнээс зохион байгуулах буй уралдаан, тэмцээнд тогтмол амжилттай оролцож байгаа нь ангийн сургалт бэлтгэлийн ахиц, бие бүрэлдэхүүний хичээл зүтгэл, хамт олны гар нийлэмжтэй ажиллагааны үр дүн юм.

Ангиас тодорхой тооны бие бүрэлдэхүүн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа ч сургуулийн жилийн нэгдүгээр үеийн цэргийн сургалт бэлтгэл, хээрийн гаралт, тактикийн хээрийн сургуулийг төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулж, төгсгөлд нь ангийн захирагчийн нэрэмжит шалгалт, цэргийн мэргэжлийн зэргийн шалгалтыг явуулсан. Бие бүрэлдэхүүн бүтээн байгуулалтын ажилд оролцохоос гадна төлөвлөгөөт сургалт, дадлауудыг



Тактикийн хээрийн сургуулиа амжилттай зохион байгууллаа

зохион байгуулан ажиллаж байна" гэж цэргийн хөдөлмөрийн гол цөм болсон сургалт бэлтгэлийн талаар тодруулж ярьсан юм.

ГАР БУУНЫ ХУРДАН БУУДЛАГЫН "МАСТЕР"



Ахмад Д.ЖАРГАЛСАЙХАН

Цэргийн алба бол аавын хүү, ээжийн охины шандсыг ямагт сорьдог хүндхэн алба. Эрчүүдтэй мөр зэрэгцэн алба хааж буй ахмад Д.Жаргалсайхан тус ангийн мэдээллийн аюулгүй байдлын офицероор ажилладаг. Тэрээр 2009 онд ҮБХИС-ийг цахилгаан холбооны инженер мэргэжлээр төгсөж, Зэвсэгт хүчний 124, 013 дугаар ангиас ажлын гараагаа эхэлжээ. 2013 онд тус ангид томилогдоноосоо хойш холбооны зангилааны дарга, албаны дарга, тасгийн даргаар ажиллаж байна. Зэвсэгт хүчний "олимп" гэгдэх Марш-тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнд 2004 оноос хойш тасралтгүй оролцсон бөгөөд 2019 онд "Цэрэгжлийн спортын мастер" болсон. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит Марш-тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнээс дөрвөн алт, Зэвсэгт хүчний Марш-тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнээс нэг хүрэл, сонсгогч байхдаа хоёр алт, нэг мөнгөн медаль хүртэж байсан бахдам амжилтын эзэн юм. "Их говийн гарнизонд алба хааж байгаагаараа бахархдаг. Аав минь Онцгой байдлын албанаас тэтгэвэртээ гарсан. Аавынхаа өмссөн хувцсыг хараад аав шигээ ийм гоё цэргийн хүн болно гэсэн мөрөөдлөө биелүүлсэн. Аавдаа энэ ангид томилогдоноо дуулгахад ихэд баярлаж, миний охин одоо л жинхэнэ офицер болох нь дээ гээд үнсэж байсан" хэмээн дурссан юм. Түүний хань тус ангийн Гал унтраах албаны дарга, хошууч О.Түвшинжаргал.

Тэд 2009 онд ҮБХИС-ийг төгссөн нэг оны офицерууд. **КОРОНАВИРУСЫН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ГОЛ АНХААРЛАА ТӨВЛӨРҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА** **Эмнэлгийн албаны дарга, дотрын эмч, ахлах дэслэгч Б.АЛТАНЧИМЭГ:**



-Дэлхий нийтэд тархаад байгаа шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж, ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж байна. Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцож буй алба хаагчдад ангийн бие бүрэлдэхүүн 3200, Ахмадын зөвлөлөөс бие бүрэлдэхүүнд 500 ширхэг амны хаалтыг оёж хандивласан. Мөн хугацаат цэргийн алба хаагчдаа амны хаалтаар тогтмол хангаж байна. Түүнчлэн өвчнөөс сэргийлэх хамгийн чухал аргуудын нэг болох сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг мэдээллийн самбар, ангийн цахим хаягаар хүргэх, зурагт хуудас хэвлэн байршуулах, Зүүнбаян тосгоны иргэдэд тараах,

үүрэн телефоны утсаар бие бүрэлдэхүүндээ мэдээлэх зэрэг арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж байна. Бүтээн байгуулалтын ажил ид өрнөж, хөл хөдөлгөөн ихтэй байгаа энэ үед халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн эрчийг сулруулахгүй, улам нягт нямбай, харуцлагатай, ухамсартай, сонор сэрэмжтэй байхыг хичээж байна. Мөн Сайншанд-Зүүнбаян чиглэлд хөдөлгөөн үйлдэж буй иргэд, тээврийн хэрэгсэлд хяналт тавих, ариутгал хийх ажлыг гурван ээлжээр зохион байгуулж байгаа.

ИДЭВХ ЗҮТГЭЛТЭЙ АХЛАХ АХЛАГЧ



Ахлах ахлагч Ж.УРАНЖАРГАЛ

Мотобуудлагын ротын ахлагч, ахлах ахлагч Ж.Уранжаргал тус ангид дөрөв дэх жилдээ ажиллаж байна. Анх 2011 онд ҮБХИС-ийн Ахлагчийн сургуульд хуягт тээвэрлэгчийн механик жолооч мэргэжлээр төгсөж Зэвсэгт хүчний 327 дугаар ангид томилогджээ. Түүнийг хамт олон нь үргэлж бусдаас суралцаж цэргийн хэргийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлж байдаг идэвх зүтгэлтэй гэж үнэлдэг юм билээ. Ахлагчийн сургуульд байхаасаа л Зэвсэгт хүчний хэмжээнд зохиогдсон уралдаан, тэмцээнд амжилттай оролцож ирсэн бөгөөд Марш-тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээний алт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит Марш-тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээний хүрэл медальтай. Мөн 2013 онд БНӨСУ, 2016 онд Афганистан улсад тус тус үүрэг гүйцэтгэсэн туршлагатай энхийг сахиулагч юм.

ЦЭРГИЙН МЭРГЭЖИЛ ЭЗЭМШИНЭ

Байлдагч А.АТАРБАЯР:



-Би хугацаат цэргийн албанд татагдахын өмнө Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн талхны цехэд ажилладаг байсан. Анх цэргийн зарлан дуудах хуудас авчхаад баярласандаа ээждээ ч дуулгалгүй цэрэг татлагын комисс руу ганцаараа оччихоод, тэнцчихлээ гэдгээ хэлсэн. Ээж маань гайхаж "Миний хүү яваад хэрэггүй юм биш үү" гэхэд нь "Хүү нь чадна аа, цэргийн алба нэр төртэй хаагаад, их зүйлийг сураад ирнэ" гэж хэлээд авынхаа алба хааж байсан ангид томилогдож ирсэн. Анх ганцхан километр гүйж чадахгүй бахарддаг байсан бол одоо 10 километр гүйсэн ч тороод байх зүйлгүй боллоо. Урагдсан хувцсаа нөхөж цойлдоод өмсчихдөг, гар дээр төвөггүйхэн 50 сумиачихдаг гээд тоочоод байвал цэргийн албанд, тэр тусмаа их говийн гарнизонд ирээд их зүйлийг сурч байна. Алба хаах хугацаандаа нөхөрлөлийн үнэ цэнийг бүрэн бутан нь мэдэрсэн гэж хэлж болно. Ууган жилийн хугацааг хамтдаа туулж, зовлон, жаргалаа хуваалцаж байгаа болохоор цэргийн нөхөрлөл

гэдэг юугаар ч орлуулшгүй чухал юм. Халагдаад найз нөхдөө өөрийн эрхгүй санах байх даа. Цэргийн мэргэжил эзэмшиж Зэвсэгт хүчинд алба хаахыг хүсэж байгаа болохоор цаашид өөрийгөө бэлдэж, олон талаар хөгжүүлнэ.

БҮХ ЗҮЙЛИЙГ ХАМТДАА ХИЙДЭГ

НЬ ХАМГИЙН САЙХАН

Байлдагч Б.АЛТАНХУЯГ:



-Орхон аймгийн Эрдэнэт хотоос цэрэгт татагдсан. Зарлан дуудах хуудас ирэхгүй болохоор нь эр хүний заавал хаах ёстой алба гэм бодоод өөрөө очиж холбогдох хүмүүстэй уулзан цэргийн албанд мордсон. Эхлээд цэргийн алба хүнд санагдсан ч яваандаа тэр бодол минь өөрчлөгдсөн. Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгийгхээ төлөө гэдэг шиг бүх зүйлийг хамтдаа хийх нь сайхан. Цэргийн эрдэмд суралцахаас гадна эр хүний мөн чанарыг өөртөө илүү төлөвшүүлж, тэсвэр, хатуужил гээд олон зүйлийг олж авч чаддаг онцлогтой алба. Олон жилийн түүхтэй ангид алба хааж байгаадаа сэтгэл маш өндөр байгаа. Ангийнхаа дарга нар, удахгүй халагдах ах нартаа, хамт алба хааж байгаа онжавууддаа цаашид ажилд нь амжилт, эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсье.

ЯМАР Ч АЖЛЫГ ЧИН СЭТГЭЛЭЭСЭЭ ХИЙХ ХЭРЭГТЭЙ

У.ДАВГАМЯДАГ:



-Тус ангийн Ахуйн үйлчилгээний төвийн угаач, индүүчин У.Давгамядаг "Хүн ямар ч ажлыг чин сэтгэлээсээ хийх хэрэгтэй. Ажил хүнийг голохоос биш хүн ажлыг голдоггүй" гэж ярилцаж эхлэх зуурт онцолсон. Улсад тасралтгүй 28, Зэвсэгт хүчинд ес дэх жилдээ үр бүтээлтэй ажиллаж байгаа тэрээр "Миний хүүхдүүдээс ялгаа юу байх вэ?" хэмээн хугацаат цэргийн алба хаагчдын цагаан хэрэглэл, гар нүүрийн алчуур, өмд, цамцыг угааж, индүүдэж, цэвэрлэн ажлаа чин сэтгэлээсээ хийж байгаа нь үнэхээр бахархам. Ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа манлайлан 2019 оны "Хөдөлмөрийн аварга ажилтан" болсон нь түүнийг ямар ажилсаг, хийж буй ажилдаа эзэн нь болдог гэдгийг төвөггүйхэн хэлж байв. Түүнийг ажилсаг гэдэг үг ч багадаа нэгэн гэж товчхон тодорхойлж, онцлон магтъя.

Энэ цаг дор эх орныхоо бүтээн байгуулалтад өөрсдийн хувь нэмрээ оруулж, хүлээсэн үүрэг, өргөсөн тангаргаа үнэнчээр биелүүлж яваа хөдөлмөрч хамт олны хийж хэрэгжүүлж, бүтээн туурвиж буй ажил, үйлс болоод ажилдаа эзэн нь, мэргэжилдээ шилдэг нь байж чаддаг зарим алба хаагчдын тухай хүргэхийг зорьлоо. Говийн гарнизонд ажил хөдөлмөр өрнөсөөр ...

МОНГОЛ УЛСАД ГЕНЕРАЛ ЦОЛ БИЙ БОЛСНЫ 76 ЖИЛИЙН ОЙД

ЭНЭ ОНД МЭНДЭЛСНИЙХ НЬ ТЭГШ ОЙ ТОХИОЖ БУЙ 11 ГЕНЕРАЛ

Аливаа улс орны тусгаар тогтнолын нэгэн баталгаа, эх орноо хамгаалах гол хүчин нь цэрэг, арми байсаар ирсэн түүхтэй. Тиймээс цэрэг, арми байгаа цагт тэднийг удирдах дээд дарга, генералууд байх ёстой бөгөөд энэ ч утгаараа генералуудыг улс орны тусгаар тогтнолын баталгааны нэгэн гол хүчин зүйл гэж үзэж болох юм.

Анх генерал цолыг Франц улсад 16 дугаар зуунаас хэрэглэж ирсэн бөгөөд Орос улсад 1657 онд Нэгдүгээр Петр хаан армидаа хэрэглэсэн ажээ. Монголчуудын хувьд өнө эртнээс цэргийг үүсгэн байгуулж, төр улсаа сахин хамгаалж ирсэн арвин баялаг уламжлалтай бөгөөд тэрхүү цэргийг удирдах дарга, жанждаа баатар, хөлөг баатар, мянгат, түмтийн ноён гэх зэргээр нэрлэж байсан нь нэг талаараа албан тушаал боловч нөгөө талаараа цэргийн цолыг давхар илэрхийлж байсан аж.

Орчин цагийн цэргийн хэргийн

хөгжлийн чиг хандлагын дагуу шинэ маягийн цэргийг байгуулж, сургаж бэлтгэхийн хамт зэрэг дэвийг нь илэрхийлсэн цэргийн цолыг хэрэглэж эхэлсэн байна. Ингэхдээ түүхэн хөгжлийн дагуу цэргийн цолондоо хас тэмдэг, өлзий хээ, таван хошууг хэрэглэж ирсэн юм.

Олноо өргөгдсөн Монгол Улсын цэрэгт 1914 оноос нийт цэргийг зэрэг дэвтэй болгосон нь өнөөгийн цэргийн цолны үүсэл байж болох юм. Үүнээс хойш 1921, 1931, 1936, 1944, 1963, 1990, 2011 онд цэргийн цолонд өөрчлөлтүүдийг хийсэн байна.

Түүх сөхөхөд, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 22 дугаар хурлын тогтоолоор Монгол ардын хувьсгалт цэргийн дарга нарыг нийтэд нь офицер хэмээн нэрлэхээр болж, цэргийн цолыг шинэчилжээ. Улмаар МАХЦ-т 1944 онд шинээр нэвтэрсэн цэргийн дээд цол нь

генерал цол бөгөөд уг цолыг эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалах үйл хэрэгт онц гарамгай гавьяа байгуулсан цэргийн дээд дарга нарт олгох журам гаргаж, БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 52 дугаар тогтоолоор Ю.Цэдэнбал, Ж.Лхагвасүрэн нарт дэслэгч генерал, С.Балдан, Д.Дамдинхүү, С.Равдан, Б.Дорж, Г.Дагдан, Б.Шагдаржав, Г.Рэндоо, М.Зайсанов, Р.Осор нарын есөн хүнд хошууч генерал, бүгд 11 хүнд анх удаа генерал цолыг олгосон байна.

Армийн генерал цолыг 1970 оноос хэрэглэж Ю.Цэдэнбал, Б.Дорж нарт уг цолыг хүртээсэн ба хурандаа генерал цолыг 1960-аад оноос олгож Б.Цог, Ж.Лхагвасүрэн, С.Батаа, Ж.Авхиа, Б.Дорж, С.Равдан, Ж.Ёндон, С.Лувсангомбо, Б.Дэжид нарт хүртээжээ. Дэслэгч генерал цолыг 1944 оноос эхлэн олгосон ба анх

Бүх цэргийн жанжны нэгдүгээр орлогч Ж.Лхагвасүрэн, МАА-ийн Улс төрийн газрын дарга Ю.Цэдэнбал нарын 20 хүн хүртсэн байна. Хошууч генерал цолыг 1944 оноос эхлэн олгосон ба нийт 109 хүн хүртсэн юм. Тэрчлэн 2006 онд бригадын генерал цолыг анх Н.Энхбаялагт олгосноос хойш өдгөө 41 хүн энэхүү дээд офицерын цолыг хүртжээ.

Энэ бүхнийг нэгтгэж үзэхэд, 1944 онд анх генерал цол олгосноос хойших 76 жилийн түүхэнд нийтдээ 180 хүн генерал хэмээх эрхэм дээд цолыг хүртээд байна.

Монгол Улсын генералууд нь зөвхөн Батлан хамгаалах, Аюулгүй байдлыг хангах хэрэгт төдийгүй улс орны хөгжлийн бүхий л үе шатанд манлайлан оролцож ирснийг энд тэмдэглэх учиртай ба тэдгээр эрхэм хүмүүсээс мэндэлснийх нь тэгш ой 2020 онд тохиож буй 11 генерал байна. Энэ удаа тэдний намтар, үйл ажиллагааг уншигч та бүхэнд танилцуулахыг эрхэм болголоо.

ХОШУУЧ ГЕНЕРАЛ МАТРОСЫН ЗАЙСАНОВ (1910-1967)

М.Зайсанов 1910 онд төрсөн. Таван настайдаа өнчирч одоогийн Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын харьяат Райсханд үрчлэгджээ. Тэр бээр 1929-1930 онд ЗХУ-ын Москва хотод Дорно дахины хөдөлмөрдийн их сургуулийн дэргэдэх Хошууны ажилчдыг бэлтгэх нэг жилийн сургууль, 1930-1931 онд дээрх сургуулийн бэлтгэл анги, 1931-1934 онд Тамбовын морин цэргийн дунд сургууль, 1934-1937 онд К.Е.Ворошиловын нэрэмжит Оренбургийн Нисгэгч-нисэн хянагчийн 3 дугаар дунд сургууль, 1948-1951 онд Москва хотын цэргийн нисэх хүчний академид тус тус суралцаж төгсжээ.

М.Зайсанов 1925 оноос Ховд аймгийн Мал эмнэлгийн газар ажилтан, 1934-1937 онд Оренбургийн нисэхийн сургуульд суралцахын хамт монгол сурагчдын орчуулагч багш, 1937 оноос мөн сургуульд монгол курсийн багш-нисгэгч, МАХЦ-ийн Нисэх эскадрилийн дарга, 1939 оноос МАХЦ-ийн нисэх хүчний дарга, 1943 оноос нисэх дивизийн дарга, 1946 оноос Нисэх хүчний дарга бөгөөд хэлтсийн дарга, 1951



оноос Нисэх хүчний хэлтэс, нисэх холимог 5 дугаар тусгай хорооны дарга, ЦЕС-ийн Нисэх секцийн даргаар ажиллажээ. МАХЦ-ийг 1950-иад оны дунд үеэс эхлэн цомхотгон олон зуун офицерыг цэргийн албанаас бэлтгэлээр халж энгийн байгууллагуудад шилжүүлсэн юм. Үүнтэй уялдан М.Зайсанов бэлтгэлээр халагдаж 1956-1964 онд Улаанбаатар төмөр замын хамгаалалтын хэлтэст ахлах байцаагч, мөн хэлтсийн дарга, Төв засварын газарт слесарийн хэсгийн эрхлэгчээр ажиллаж байв.

Тэр бээр БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 52 дугаар тогтоолоор "Нисэхийн" хошууч генерал хэмээх анхны цол хүртсэн бөгөөд Монгол Улсын анхны 11 генералын нэг юм. Түүний хөдөлмөр, зүтгэлийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор гурван удаа, Байлдааны гавьяаны одон, "Алтан гадас" одонгоор хоёр удаа болон бусад медалиудаар тус тус шагнажээ. Мөн ЗХУ-ын Байлдааны гавьяаны улаан тугийн одон болон бусад медалиар шагнасан байна.

ХОШУУЧ ГЕНЕРАЛ ЖАМЦЫН ЦЭНД-АЮУШ (1920-1971)

Ж.Цэнд-Аюуш нь 1920 онд Сайн ноён хан аймгийн Сүжигт бэйсийн хошуу, одоогийн Архангай аймгийн Хотонт сумын нутагт төрсөн.

1942-1943 онд ЦЕС-ийн улс төрийн ангийг хурдавчилсан хөтөлбөрөөр, 1947-1949 онд Улаанбаатар хотод МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын шинэ хүчний дээд сургуулийг эчнээгээр, 1955-1959 онд ЗХУ-ын Москва хотод ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Намын дээд сургуульд суралцаж төгсжээ. Ж.Цэнд-Аюуш нь 1940 онд Баянтүмэн дэх 5 дугаар морьт дивизид цэрэг, бага дарга, 1943-1944 онд тус дивизийн холбооны тусгай сумангийн улс төрийн удирдагч, 1944-1946 онд тус дивизийн 28 дугаар морьт хорооны намын товчооны дарга, 1946-1947 онд мөн дивизийн улс төрийн хэлтсийн намын ажлын зааварлагч, 1947-1951 онд МАХЦ-ийн Улс төрийн газарт хэлтсийн орлогч, 1951-1952 онд Улс төрийн газрын шинэ хүчний хэлтсийн дарга, 1952-1953 онд 6 дугаар мотомеханикжуулсан бригадын улс төрийн хэлтсийн дарга, 1953-1954 онд Улс төрийн газрын орлогч бөгөөд нам, эвлэлийн ажлын хэлтсийн дарга, 1954



оноос Улс төрийн газрын орлогч дарга, 1954-1955 онд Улс төрийн газрын дарга, 1959-1960 онд Ардын цэргийн командлагчийн орлогч бөгөөд Ардын цэргийн Улс төрийн газрын дарга, 1960-1962 онд Архангай аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, 1962-1969 онд Ардын цэргийн Улс төрийн газрын дарга, 1969-1971 онд Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хорооны орлогч даргаар ажиллаж байв. Тэрээр 28 дугаар морьт хорооны намын товчооны даргаар ажиллаж байхдаа 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон бөгөөд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1965 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор хошууч генерал цол хүртжээ. Түүний эх орноо Батлан

хамгаалах, Зэвсэгт хүчийг бэхжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одон, "Алтан гадас" одон, бусад ойн медалиудаар шагнасан бөгөөд ЗХУ-ын Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Польш улсын Эрх чөлөөний нэгдүгээр зэргийн одон, бусад медалиар шагнажээ.

ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ ЖҮГДЭРИЙН БАЛЖИННЯМ (1930-2002)

Ж.Балжинням нь 1930 онд одоогийн Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын нутагт төрсөн. 1940-1944 онд бага сургууль, 1961-1962 онд Улаанбаатар хотод худалдааны удирдах ажилтны курс, 1964-1969 онд ЗХУ-ын Москва хотод В.И.Лениний нэрэмжит Цэрэг-улс төрийн академи, 1979 онд Москва хотод прокурорын дээд курс, 1981 онд Москва хотод ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны академийн дээд курст тус тус суралцан төгсжээ.

Тэр бээр 1947-1951 онд сумын улаан булангийн эрхлэгч, эвлэлийн үүрийн даргаар ажиллаж байгаад цэргийн албанд татагдаж 1951-1954 онд МАХЦ-ийн Жанжин штабын хамгаалах суманд цэрэг, Улсын дээд шүүхийн цэргийн колледжд бичээч, нарийн бичгийн дарга (1953 онд офицер болсон)-аар ажиллаж байгаад 1955, зохион байгуулалтын өөрчлөлтөөр цэргийн коллеги татан буугдсан учир цэргийн албанаас халагдсан. Улмаар 1954-1960 онд Улаанбаатар төмөр замын худалдааны албанд нярав, барааны мэргэжилтэн, хэлтсийн дарга, 1960-1964 онд Улаанбаатар төмөр



замын хэрэг эрхлэх газрын худалдааны албаны даргын албыг хашиж байгаад 1964 онд цэргийн албанд дахин ирж, 1969-1972 онд Цэргийн ерөнхий прокурорын орлогч, 1972-1978 онд Улсын прокурорын орлогч, 1978-1980 онд Улсын прокурорын орлогч бөгөөд Цэргийн ерөнхий прокурор, 1980-1982 онд МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын хянан шалгах хорооны орлогч дарга, 1982-1988 онд МАА-ийн Улс төрийн газрын дарга, 1988-1990 онд БНМАУ-ын Ерөнхий прокурор, төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөхөөр ажиллаж байгаад тэтгэвэрт гарчээ.

Түүнд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1978 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор хошууч генерал, 1982 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 325 дугаар тогтоолоор дэслэгч генерал цол хүртээсэн бөгөөд хөдөлмөр, зүтгэлийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одон, "Алтан гадас" одон болон бусад медалиуд, ЗХУ, БНБАУ, БНПАУ, БНСЧСУ, БНСВУ-ын одон, медалиудаар шагнажээ.

ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ ЦАГААНЫ САМДАНГЭЛЭГ (1910-1994)

Ц.Самдангэлэг нь 1910 онд Дөрвөдийн зүүн гарын чуулган төгс хүлэг Далай ханы аймгийн Эетэй засгийн хошуу, одоогийн Увс аймгийн Тэс сумын нутагт төрсөн. 1933-1934 онд Бага даргын сургууль, 1934-1938 онд ЗХУ-ын Тамбов хотын морин цэргийн дунд сургууль, 1942-1946 онд Москва хотод М.В.Фрунзийн нэрэмжит Цэргийн академи, 1957-1960 онд ЗХУ-д В.И.Лениний нэрэмжит Цэрэг-улс төрийн академийн адъюнктурт суралцан төгсжээ. Тэрээр 1932-1934 онд цэрэг, 1934 онд Цэргийн ерөнхий сургуулийн улс төрийн суманд сурагч, 1938-1939 онд Цэргийн ерөнхий сургуульд сумангийн дарга, буудлагын удирдагч, 1939-1940 онд Өлгийн хийд дэх 10 дугаар морьт дивизийн дарга, 1940-1942 онд Матад дахь 8 дугаар морьт дивизийн дарга, 1946-1948 онд Тамсагбулаг дахь 6 дугаар морьт дивизийн дарга, 1948-1949 онд МАХЦ-ийн Жанжин штабын тагнуулын хэлтсийн дарга, 1949-1983 онд МУИС-ийн цэрэг, биеийн тамирын кафедр, тусгай бэлтгэлийн тэнхим, иргэний хамгаалалтын тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байгаад тэтгэвэрт гарчээ.

Ц.Самдангэлэг 1960 онд ЗХУ-д түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан



Монголын цэргийн түүхийн анхны эрдэмтэн, доцент бөгөөд түүнд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор хошууч генерал, 1971 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 68 дугаар тогтоолоор дэслэгч генерал цол хүртээжээ. Түүний улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Сүхбаатарын одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одонгоор хоёр удаа, "Алтан гадас" одонгоор гурван удаа болон бусад медалиар шагнажээ.

ХОШУУЧ ГЕНЕРАЛ ДОНОЙН БЯМБАА (1930-2012)

Д.Бямбаа нь 1930 онд Хантайшир уулын аймгийн Дэлгэрхан уулын хошуу, одоогийн Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын нутагт төрсөн.

1946-1952 онд Д.Сүхбаатарын нэрэмжит Офицерын сургууль, 1952-1954 онд Цэргийн Ерөнхий сургууль, 1963-1966 онд ЗХУ-ын Москва хотод М.В.Фрунзийн нэрэмжит Цэргийн академид тус тус суралцаж төгсжээ.

Д.Бямбаа нь 1946 оноос цэргийн алба хааж, 1954-1955 онд Цэргийн ерөнхий сургуульд курсийн дарга, 1956 онд Хүндэт харуулын ротод салааны дарга, 1957-1959 онд буудлагын 6 дугаар батальоны ротын дарга, 1959-1961 онд мотобуудлагын 5 ба 7 дугаар батальоны ротын дарга, 1966-1967 онд мотобуудлагын нэгдүгээр тусгай бригадын штабын орлогч, штабын дарга, 1970-1976 онд МАА-ийн Жанжин штабын нэгдүгээр орлогч бөгөөд хэлтсийн дарга, 1976-1983 онд БХЯ-ны орлогч сайд бөгөөд МАА-ийн Ар талыг удирдах газрын дарга, 1983-1990 онд Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн орлогч даргаар ажиллаж байгаад тэтгэвэрт гарчээ.



Түүнд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1973 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 80 дугаар тогтоолоор хошууч генерал цол хүртээсэн бөгөөд эх орноо батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь төр, засгаас өндөр үнэлж Сүхбаатарын одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одон болон бусад медалиар шагнажээ.

ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ ШАГАЛЫН ЖАДАМБА (1940-1996)

Ш.Жадамба нь 1940 онд Говь-Алтай аймгийн Халиун сумын нутагт Дунд Улиастайн голд төрсөн бөгөөд 1948-1956 онд дунд сургууль, 1961-1964 онд ЗХУ-ын Благовешенск хотын Ерөнхий цэргийн дунд сургууль, 1967-1970 онд ЗХУ-ын Москва хотод М.В.Фрунзийн нэрэмжит Цэргийн академи, 1974-1976 онд Москва хотод К.Е.Ворошиловын нэрэмжит ЗХУ-ын Зэвсэгт хүчний Жанжин штабын академид тус тус суралцан төгсжээ. Тэрээр цэргийн бүх шатны сургуулийг бүгдийг нь алтан медальтай төгссөн Монголын анхны төгсөгч юм.

Ш.Жадамба дунд сургууль төгсөөд мал маллахын зэрэгцээ эвлэлийн идэвхтэн, ухуулагчаар ажиллаж байгаад цэргийн албанд татагдаж 1960-1961 онд армийн химийн тусгай ротод цэрэг, 1964-1965 онд ЦЕДС-д курсийн дарга, 1965-1967 онд тус сургуульд тактикийн багш, 1970-1971 онд Ардын Армийн Жанжин штабын Оперативын хэлтэст чиглэл хариуцсан офицер, 1971-1973 онд Оперативын хэлтэст оперативын бэлтгэлийн тасгийн дарга, 1973-1974 онд Оперативын хэлтсийн орлогч, оператив тасгийн дарга, 1976-1979 онд Ардын Армийн Жанжин штабын нэгдүгээр орлогч, Оперативын хэлтсийн дарга, 1979-1981 онд Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч бөгөөд Оперативын газрын дарга, 1981-1986 онд БХЯ-ны орлогч сайд, 1986-1990 онд БХЯ-ны нэгдүгээр орлогч сайд бөгөөд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, 1990-1992 онд Батлан хамгаалах яамны сайд, 1992-1996 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар ажиллаж байлаа.

Түүнд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1978 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 107 дугаар тогтоолоор хошууч



генерал, 1986 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 88 дугаар тогтоолоор дэслэгч генерал цол хүртээсэн юм. Түүний улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмэр, хөдөлмөр, зүтгэлийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Сүхбаатарын одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одон, "Алтан гадас" одон болон бусад медалиуд мөн ЗХУ, Герман, Чехословак, Вьетнам, Лаос, Польш зэрэг улсын одон, медалиудаар шагнажээ.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 2012 онд Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийг дэслэгч генерал Ш.Жадамбын нэрэмжит болгон түүний алдар гавьяаг нь мөнхөлсөн юм.

ХОШУУЧ ГЕНЕРАЛ ЧОЙЖИЛЫН ПҮРЭВЖАВ (1930-2000)

Ч.Пүрэвжав нь 1930 онд одоогийн Завхан аймгийн Тэлмэн сумын нутагт төрсөн. 1943-1947 онд Завхан аймгийн Тэлмэн сумын бага сургууль, 1947-1950 онд Улаанбаатар хотод Зоо-мал эмнэлгийн техникум, 1950-1955 онд Монгол Улсын Их Сургуулийн Зоо-мал эмнэлгийн ангид суралцаж төгссөн.

Тэрээр 1950 оноос Сүхбаатар аймагт малын бага эмч, 1955-1958 онд Сүхбаатар аймгийн Онгон, Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын малын их эмч, Завхан аймгийн мал эмнэлгийн ерөнхий эмч, 1958-1975 онд МХЗЭ-ийн Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, 1975-1976 онд МАХН-ын Төв Хорооны намын байгууллагын хэлтэст ажилтан, 1976-1984 онд МАХН-ын Төв Хорооны Барилгын хэлтсийн орлогч эрхлэгч, 1984-1985 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Авто замын барилгын газрын харьяа Баруун чиглэлийн зам барилгын трестийн дарга, 1985-1987 онд Хөнгөн ба хүнсний үйлдвэрийн яамны Барилга захиалагчийн товчооны хяналтын инженер, 1987-1988 онд Ноосны үйлдвэрийн нэгдлийн Барилга захиалагчийн группийн хяналтын инженер, 1989 онд Эсгий, эсгий гутлын үйлдвэрийн Барилга захиалагчийн төлөөлөгч, 1989-1990 онд Улсын барилгын хорооны төлөөлөгч зэрэг ажил эрхэлж байгаад тэтгэвэрт гарчээ.



Түүнд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 22 дугаар тогтоолоор хошууч генерал цол хүртээсэн бөгөөд хөдөлмөр, зүтгэлийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор хоёр удаа, "Алтан гадас" одон, бусад медаль мөн ЗХУ, БНАГУ-ын медалиудаар шагнажээ.

ХОШУУЧ ГЕНЕРАЛ ЧОГИЙН САНДР (1950-2017)

Ч.Сандр 1950 онд Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт төрсөн бөгөөд 1958-1968 онд дунд сургууль, 1968-1973 онд ЗХУ-д Хилийн цэргийн дунд сургууль, 1976-1977 онд ЗХУ-д Хилийн цэргийн дээд курс, 1982-1985 онд Москва хотод М.В.Фрунзийн нэрэмжит Цэргийн академид суралцаж төгсжээ.

Тэрээр 1973-1975 онд Хилийн 0166 дугаар ангид штабын байлдааны бэлтгэл сургуулийн офицер, 1975-1976 онд мөн ангид заставын дарга, 1977-1979 онд Хилийн 0214 дүгээр ангийн штабын нэгдүгээр тасгийн дарга, 1979-1982 онд Хилийн 0166 дугаар ангийн штабын дарга, 1985-1989 онд мөн ангийн захирагч, 1989-1990 онд Хилийн ба Дотоодын цэргийг удирдах Ерөнхий газрын штабын байлдааны бэлтгэл сургууль, цэргийн албаны зохион байгуулалтын хэлтэст ахлах офицер, 1990 онд Хилийн ба Дотоодын цэргийн штабын нэгдүгээр хэлтсийн орлогч дарга, 1990-1993 онд Улсын Аюулгүй байдлыг хангах Ерөнхий газрын тэргүүн дэд бөгөөд Хилийн цэргийн дарга, 1994 онд Хилийн цэргийн удирдах газрын Эрдэм шинжилгээний төвд мэдээлэл, судалгааны секторын даргаар ажиллаж байв.

Түүнд БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн



53 дугаар зарлигаар хошууч генерал цол хүртээсэн бөгөөд түүний хөдөлмөр, зүтгэлийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одон болон бусад медалиар шагнажээ.

ХОШУУЧ ГЕНЕРАЛ БИЛЭГГИЙН БАНЗРАГЧ (1930-2000)

Б.Банзрагч нь 1930 онд Богдхан уулын аймгийн Богдхан уулын хошуу, одоогийн Төв аймгийн Баянцогт сумын нутагт Дулаан гэдэг газар төрсөн.

1938-1947 онд бага, дунд сургууль, 1951-1955 онд Улаанбаатар хотод МУИС-ийн утга зохиол, хэл бичгийн анги, 1961-1963 онд Москва хотод ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Намын дээд сургуульд тус тус суралцаж төгсжээ.

Тэрээр 1948-1951 онд Улсын номын сангийн ном олгогч, фондын эрхлэгч, 1955-1956 онд МАХН-ын Төв Хорооны суртлын хэлтсийн лектор, зааварлагч, тасгийн эрхлэгч, 1956-1959 онд Улаанбаатар хотын Намын хорооны суртал ухуулгын хэлтсийн эрхлэгч, 1959-1961 онд Улаанбаатар хотын ХЗЭ-ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, 1963-1966 онд Сэлэнгэ аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, 1966-1969 онд Өмнөговь аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, 1969-1982 онд БНМАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яамны 3 дугаар хэлтсийн дарга, 1982-1985 онд БНМАУ-аас ЗХУ-ын Киев хотод суух Ерөнхий консул, 1985 оноос Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудыг удирдах газрын намын хорооны нарийн бичгийн дарга, 1990 онд УАБХЕГ-ын Архив бүртгэлийн албанд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн хэргийг хянан цагаатгах салбар комиссын нарийн бичгийн даргаар ажиллаж байгаад тэтгэвэрт гарчээ.

Түүнд БНМАУ-ын Сайд нарын



Зөвлөлийн 1979 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 226 дугаар тогтоолоор хошууч генерал цол хүртээсэн бөгөөд түүний хөдөлмөр, зүтгэл, улс орны аюулгүй байдлыг хангах үйлсэд оруулсан хувь нэмрийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Байлдааны гавьяаны одон, "Алтан гадас" одонгоор хоёр удаа, бусад ойн медаль, Хүндэт чекист цол, ЗХУ-ын Улаан таван хошуу одон, БНАГУ, БНСЧСУ-ын медалиудаар шагнасан юм.

ХОШУУЧ ГЕНЕРАЛ БАТМӨНХИЙН АМАРСАЙХАН (1910-2003)

Б.Амарсайхан 1910 онд Сэцэн хан аймгийн Үйзэн вангийн хошуу, одоогийн Дорнод аймгийн Матад сумын нутагт төрсөн бөгөөд 1924-1927 онд Матад уулын хошууны тэнхимийн сургуульд суралцаж төгсжээ.

Тэрээр 1928 оноос Дорнод аймгийн эвлэлийн хорооны дарга, 1931 оноос тус аймгийн намын хорооны тэргүүлэгч гишүүн бөгөөд суртлын хэлтсийн эрхлэгч, 1932 оноос МАХН-ын Төв Хорооны зааварлагч, мэдээ боловсруулагч, "Үнэн" сонин нарийн бичгийн даргаар ажиллаж байсан ба 1934 онд цэргийн албанд ирж Дотоодыг хамгаалах газрын төлөөлөгч, отрядын гүйцэтгэх ангийн дарга, Бүх цэргийн жанжны нарийн бичгийн дарга, 1937 оноос МАХЦ-ийн Улс төрийн газрын орлогч даргаар ажиллаж байжээ. Мөн 1946 оноос Дорнод аймгийн болон Матад сумын хүн эмнэлгийн сувлагч, бага эмч, аймгийн Улаан загалмай нийгэмлэгийн хорооны орлогч даргаар ажиллаж байгаад 1972 онд өндөр насны тэтгэвэрт гарчээ.

Б.Амарсайханыг улс төрийн хилс хэргээр 1940 оны 2 дугаар сарын 5-ны өдөр шийтгэж, цагаатгах ажлыг эрхлэх комиссын 1957 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор цагаатгасан байна.

Түүнд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 412 дугаар тогтоолоор



хошууч генерал цол хүртээжээ. Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хошууч генерал Б.Амарсайханы хөдөлмөр, зүтгэлийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, "Алтан гадас" одон болон бусад медалиар шагнасан юм

ХОШУУЧ ГЕНЕРАЛ МИХЛАЙН БОРБААТАР (1950-2017)

М.Борбаатар 1950 онд Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт төрсөн бөгөөд 1958-1968 онд Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотын 10 жилийн дунд сургууль, 1969-1974 онд ЗХУ-д Цэргийн холбооны дээд сургууль, 1979-1982 онд Москва хотод М.В.Фрунзийн нэрэмжит Цэргийн академи, 1996 онд ОХУ-ын Москва хотод К.Е.Ворошиловын нэрэмжит Зэвсэгт хүчний Жанжин штабын академийн дээд курс, 2001-2002 онд БНХАУ-ын Үндэсний Батлан хамгаалахын академийн дээд албан тушаалын удирдах офицеруудыг бэлтгэх дамжаа, 2004 онд АНУ-ын Батлан хамгаалах яамны Аюулгүй байдлын судалгааны төвийн дээд албан тушаалтны семинарт тус тус суралцаж төгсжээ.

Тэрээр МУИС-д суралцаж байгаад 1968 онд цэргийн албанд татагдан ирж, Ардын Армийн 120 дугаар ангид байлдагч, бага дарга, 1974-1977 онд Ардын Армийн 2 дугаар мотобуудлагын бригадын холбооны салааны захирагч, холбооны ротын техникийн орлогч, ротын захирагч, 1977-1979 онд БХЯ-ны нэгдүгээр орлогч сайдын адъютант, 1982-1984 онд Ерөнхий цэргийн 5 дугаар армийн Оперативын хэлтэст офицер, ахлах офицер, 1984-1990 онд Зэвсэгт хүчний Жанжин штабын Нэгдүгээр газарт офицер, ахлах офицер, Оперативын хэлтсийн тасаг, хэлтсийн дарга, 1990-1996 онд Цэргийн их сургуулийн Ерөнхий цэргийн тэнхимийн дарга, ахлах багш, 1996-1998 онд Зэвсэгт хүчний Ерөнхий штабын Сургалт, соёл хүмүүжлийн газрын орлогч дарга, 1998-2002 онд ЗХЖШ-ын Сургалт, зохион байгуулалт эрхэлсэн орлогч, 2002-2006 онд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч, Цэргийн удирдлага, стратегийн төлөвлөлтийн




газрын дарга, 2006 оноос БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, 2011 оноос БНСУ-д суугаа цэрэг, агаарын цэргийн атташегаар ажиллаж байсан.

Түүнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 30 дугаар зарлигаар хошууч генерал цол хүртээсэн бөгөөд түүний хөдөлмөр, зүтгэлийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, "Алтан гадас" одон, Цэргийн хүндэт медаль болон бусад медалиар шагнасан юм.

БНМАУ-ЫН МАРШАЛ Г.ДЭМИДИЙН МЭНДЭЛСНИЙ 120 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАВ

ЦЭРГИЙН НЭРТ ЗҮТГЭЛТЭН МАРШАЛ ГЭЛЭГДОРЖИЙН ДЭМИД



Д.Гомбосүрэнгийн нэрэмжит Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хошууч Т.СУХБААТАР

XX зууны Монголын төр, цэргийн нэрт зүтгэлтэн нэгэн эрхэм бол БНМАУ-ын анхны өрлөг жанжин (маршал), Бүх цэргийн жанжин Гэлэгдоржийн Дэמיד билээ.

Г.Дэמיד болбоос 1900 онд Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Их тамир сумын Хан-Өндөр багийн нутаг Шар булан хэмээх газар малчин ард Гэлэгдоржийнд төржээ. Тэрээр бага балчир байхаасаа хөдөлгөөн ихтэй, ухаалаг, сэргэлэн цовоо, ой сайтай хүү байсан учир түүнийг Хан-Өндөрийн хүрээнд лам болгохоор явуулжээ. Г.Дэמיד тус хүрээнд амьдарч, ажиллаж байсан хятад, орос, дани, төвөд, монгол лам, хувраг, худалдаачин, малчин зэрэг таван хэлийн олон хүмүүсийн дунд орж, тэдэнд үйлчилж, наймаа арилжаа, худалдаа үйлчилгээ, хөдөлмөр, үзэл санаа, зан чанарыг өөрийн нүдээр үзэж, биеэр мэдэрч, өөрөөр хэлбэл, олон янзын хүмүүсийн дунд орж ажилласнаар тухайн үеийн Монгол орны нийгмийн амьдралыг танин мэдэж авсан бөгөөд ирээдүйн улс төр, цэрэг арми, нийгмийн зүтгэлтэн болох мэдрэмжийг нь нээж өгсөн байна.

Ардын хувьсгалын он жилүүдэд сайн дураараа Ардын журамт цэрэгт элсэн орж, 1921 оны дунд үеэр Идэр, Чулуутай, Цэцэрлэг, Туул голын адаг ба Борнуур, Шарын гол, Сэлэнгэ, Ерөө, Хэрлэн зэрэг газар цагаантны эсрэг хийсэн хэд хэдэн байлдаанд оролцсон партизан бөгөөд Ардын хувьсгал, Ардын засгийг бэхжүүлэхийн төлөө анхнаас нь идэвх зүтгэлтэй, тууштай оролцсон нэгэн билээ.

Ардын хувьсгал ялсны дараагаар Г.Дэמיד цэргийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх үүднээс 1922 онд Ардын цэргийн даргын сургуульд элсэн суралцаж 1923 онд төгсжээ. Сургуулиа төгсөөд Ардын цэргийн даргын сургуульдаа курсийн дарга, сумангийн туслах, сумангийн дарга, захирлын туслахаар ажиллаж байгаад 1926-1929 онд ЗХУ-ын Тверь хотын Морин цэргийн дунд сургуульд суралцаж байжээ.

Монгол оронд 1930-аад оны эхээр өрнөж байсан "баруунтан", "зүүнтэн"-ий тэмцлийн нэн эгзэгтэй үед тэрээр цэрэг, улс төрийн замналаа эхлүүлсэн байдаг. Түүнийг сургуулиас нь дуудан ирүүлж төрийн өндөр хариуцлагатай албан тушаалд тохоон томилжээ. Тухайн үеийн Засгийн газрын 1930 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 12 дугаар хурлын тогтоолоор "Тус цэргийн дээд эрхийг барих газрын байгуулалт нь ажил явуулгад хараахан тохироогүй буюу завсрын илүүдэл чирэгдэл бүхий зүйл үлэмжхэн болох тул ЗХУ-ын Улаан цэргийн байгуулалтыг үлгэрлэж, тайван цагийн байгуулалтаар шинэчлэн өөрчилбөөс зүйтэй тул Цэргийн яам хэмээн нэрийдэхийг зогсоож, БНМАУ-ын Хувьсгалт Улаан цэргийн Бүх Ерөнхий штаб

хэмээн нэрийдэх ба Цэргийн зөвлөлийг БНМАУ-ын Хувьсгалт Улаан цэргийн зөвлөл хэмээн нэрийдэж, басхүү сайд, жанжин хэмээн нэрийдэлгүй болгон, хэрэв байлдааны цаг тохиолдох ахул Бүх цэргийн байцаагчид Бүх цэргийн жанжны тушаалыг хүлээлгэж, тухайн хэргийг эрхлэн гүйцэтгүүлэх" болжээ. Улмаар БНМАУ-ын 15 дугаар Бага Хурлын 1930 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдүгээр хурлын тогтоолоор Хувьсгалт Улаан цэргийн зөвлөлийн тэргүүлэгчээр Г.Дэмидийг сонгон баталжээ. Ийнхүү Цэргийн яамыг татан буулгаж, цэргийн удирдах дээд байгууллагыг Г.Дэמיד хэмээх шинэ хүн толгойлох болов.

Зүүнтний нугалаа, завхралыг баруунтны тал засаж заруулан "Шинэ эргэлтийн бодлого"-ыг 1932 оны 7 дугаар сарын 2-ны өдөр хуралдсан Улсын 17 дугаар Онц Бага Хурлаас тунхагласан билээ. Тус хурлаас засгийн албан газруудын байгуулалтыг өөрчлөн тогтоож, Цэргийн яамыг сэргээн байгуулсан бөгөөд "Цэргийн яамны сайд бол Бүх цэргийн жанжин бөгөөд Хувьсгалт цэргийн зөвлөлийн тэргүүлэгч болно" гэж заав. Бага хурлаас Цэргийн явдлын яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжин, Хувьсгалт цэргийн зөвлөлийн тэргүүлэгчээр Г.Дэмидийг баталжээ. Энэ цаг үеэс Г.Дэמיד таван жилийн туршид Цэргийн явдлын яамыг толгойлон улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэхийн төлөө тууштай ажилласан байна.

Түүний Цэргийн явдлын яамыг толгойлон 1930-аад оны эхээр Монгол Улсын гадаад, дотоод орчин ихээхэн ээдрээтэй байсан цаг үе юм. Зүүн хойд Хятадад Японы милитаризм ид хүчээ авч, Японы тагнуул идэвхжин Монголын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд заналхийлж байсан үе юм. Тэрээр хэдийгээр цэргийн дунд боловсролтой морьт цэргийн дарга байсан ч угийн байгалиас заяасан сод ухаан, зохион байгуулах асар их авьяас, чадвар нь цэргийн нэрт зүтгэлтний хэмжээнд хүргэжээ.

Мөн Монгол Улсын дотоод нөхцөл байдал ч хүндхэн байсан юм. Тухайлбал, 1932 онд төрийн эсрэг гаднын оролцоотой хувьсгалын эсэргүү гэх ард түмнийг хамарсан бослого, хөдөлгөөн гарсан хүнд цаг үе, сорилт бэрхшээл дагуулсан он жилүүд байсан юм. Ялангуяа Монгол Улсын батлан хамгаалах хүчин чадал 1921 оноос хурдацтай дээшлэн байлдах чадвар бүхий Монгол Ардын Хувьсгалт цэрэг гэж тодорхойлж байсан ч 1932 оны хувьсгалын эсэргүү бослогоор Зөвлөлтийн тусламжтайгаар арай хийж ялсан нь энэ салбарт томоохон шинэчлэл хийх шаардлагатайг харуулсан. Нөгөө талаар гаднын дайсны өмнө БНМАУ-ын батлан хамгаалах хүчин бэлэн бус байгааг харуулсан үйл явдал болсон юм. Иймээс Монгол Улсын батлан хамгаалах хүч чадлыг зузаатгах явдал маршал Г.Дэмидийн цэргийн үйл ажиллагааны гол чиг шугам байсан гэж хэлж болно. Тэрээр "Байлдаан дэгдэх ахул тус улсын эдийн засгийн ба улс төрийн байдлыг

байлдааны цагийн явдалтай тохируулах нь чухал болох бөгөөд бүх улс, мөн аж ахуй ба засаг захиргааны зэрэг олон нийтийн газрууд хийгээд олон түмэн ардаас улсыг батлан хамгаалах хэрэгт оролцохоор бэлхэн байваас зохино" гэж батлан хамгаалах үйл хэрэг нь бүх нийтийн хэрэг болохыг онцлон тэмдэглэж байв.

Монгол Улсын гадаад, дотоод орчин хурцадсан тэр үед түүнийг Бүх цэргийн зөвлөлийн дэргэд Ерөнхий сайдаар толгойлуулан байгуулагдсан Улсыг хамгаалах комиссын орлогч даргаар томилсон юм. Уг комисс нь улс орныг болзошгүй дайнд бэлэн байлгах, түүнд тохирсон хүн, техникийн хүчээр нөхөн хангах, улсыг батлан хамгаалах дээд байгууллага байжээ.

Г.Дэмидийн улс орныг батлан хамгаалах талаар хийсэн олон талт ажлын нэг нь 1935 онд түүний гарын үсэг зурж баталсан "БНМАУ-ыг батлан хамгаалах байлдааны төлөвлөгөө" юм. Энэ төлөвлөгөө нь тухайн үедээ Монгол Улсын хувьд шинэ, анхдагч зүйл байсан бөгөөд түүнд дайсан довтолж болзошгүй үндсэн чиглэлүүдийг тодорхойлж, түрэмгийллийг няцаахад хэрхэн яаж бэлтгэх, дайн, байлдааны аюул тохиолдсон үед улс орныг батлан хамгаалах, бэлэн байдлын төлөвлөгөө, дайчилгаа явуулах болон МАХЦ-ийн нэгтгэл, ангиудыг байлдаанд оруулах, стратеги, тактик, оперативын зэрэг цогцолбор асуудлыг тусгасан нэн чухал баримт бичиг байв.

Тэрээр улс орныг батлан хамгаалах ажлын хүрээнд улсын хэмжээний болон цэргийн дайчилгааны асуудлыг онц чухалчлан үзэж, багагүй зүйлийг санаачлан хэрэгжүүлсэн юм. Монгол Улсад энэ талаар 1932 оныг хүртэл улс орныг хамарсан цэгцтэй бодлого, төлөвлөгөө байгаагүй ажээ. Г.Дэמיד дайчилгааны ажлыг онцлон үзэж, улсын яам, төв, орон нутгийн албан байгууллагуудыг дайчилгааны төлөвлөгөөтэй болгон хийх ажил, үүргийг нь тодорхойлж өгөхийн зэрэгцээ шалган туслах ажлыг байнга хийж байсныг дурдах нь зүйтэй. Аймаг, хотын цэргийн хэлтсийн дарга, ажилтнуудыг удаа дараа түр сургууль, цугларалтаар улс орныг батлан хамгаалах бодлого, арга ажиллагаанд сургаж байв. Дээрх арга хэмжээний үр дүнд 1930-аад оны дунд үе гэхэд дайчилгааны ажил цэгцэрч улс орныг хамарсан нэгдсэн тогтолцоо бий болсон байна.

Г.Дэמיד ЗХУ-д суралцаж байх хугацаандаа Зөвлөлтийн цэргийн нэрт жанжнууд, цэргийн зүтгэлтнүүдээс суралцан тэдний ажлын туршлага, арга барил зэргийг МАХЦ-т нутагшуулах ажлыг хийж, бодож, төлөвлөж байсан юм. Ялангуяа ЗХУ-ын маршал М.Н.Тухачевскийн цэргийн шинэчлэлийг тууштай баримталж байсан нь МАХЦ-т ихээхэн хэрэгтэй зүйл байжээ. Монгол орон бол дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн бөгөөд механикжсан байлдааны техник тун цөөн, түүнийг дагаад боловсон хүчин харьцангуй сул байсан. Тиймээс Г.Дэמיד морьт-механикжуулсан цэргийг хослуулан тохиромжтой хэмээн үзэж байсан билээ. Цэргийн түүхч Д.Гомбосүрэн абугай "Дэмидийг механикжсан морьт цэргийн байгуулалтыг үндэслэгч" хэмээн нэгэнтээ хэлж байсан нь түүхэн үнэн юм. Мөн МАХЦ-ийг Европын янз маягийн байдал бүхий цэрэг болгох бодлогыг баримталж байсныг дурдах нь ч зүйтэй. Үүний үр дүнд МАХЦ-ийн дотор орчин үеийн шинэ зэвсэг, танк, хими, холбоо, нисэх онгоц, төрөл бүрийн автомашин, техникээр зэвсэглэсэн төрөл мэргэжлийн цэргийн эзлэх хувийн жин мэдэгдэхгүй өссөн юм. Зөвхөн 1934 оны байдлаар МАХЦ нь 60 орчим хувиар техникжсэн байна.

Мөн тэр бээр орон нутгийн хамгаалалтын асуудалд онцгой

анхаарч орон нутгийн цэргээс бүрдсэн хэд хэдэн дивиз, хороог байгуулан олон зуун залуусыг богино хугацаанд цэргийн эрдэмд сургасан нь цэргийн алба хаах явдлыг хөнгөвчилсөн, нөгөө талаар дайн бүхий байдлын үед бүх цэргийн тоог хурдан хугацаанд нэмэгдүүлэх боломжийг хангаж өгчээ. Орчин үеийн орон нутгийн хамгаалалтын тогтолцоог Г.Дэמיד тэртээ 1930-аад оны үед хэрэгжүүлэх гэж оролдож байсан нь өнөөдөр ач холбогдол нь буураагүй, харин ч яг тохиромжтой алсыг харсан бүтэц гэж харагдаж байна.

Г.Дэמיד нь цэргийн нэрт стратегич, онолч байсан юм. Тэрээр 1930-аад оны үеийн бус нутгийн цэрэг, улс төрийн байдалд дүн шинжилгээ хийж Японы зүгээс одоохондоо БНМАУ-ын нутаг дэвсгэрт шууд халдан довтолж аюул хараахан үгүй гэсэн дүгнэлт хийсэн нь зөв байсан юм. Дайн гарвал хүчирхэг улсуудын хооронд болж Монгол Улс түүнд татагдан орж болзошгүй гэсэн дүгнэлт хийсэн нь хожим 1939 оны Халхын голын дайнаар тодорхой харагдсан. Тиймээс ч тэрээр ямар нэгэн шалтгаангүйгээр Зөвлөлтийн цэргийг Монголд байрлуулахыг эсрэг байсан бөгөөд энэ нь улс хоорондын итгэлцлийг эвдэн дайны галыг өдөөж болзошгүй гэж дүгнэж байжээ. Энэ дүгнэлт нь хожим хойно ч сургамжтай үйл явдал болсон. Зөвлөлтийн цэрэг 1990 он хүртэл манай улсад байрласан он жилүүд нь улс хоорондын итгэлцлийг эвдэн хүйтэн дайны галыг улам өдөөн тэр ч бүү хэл АНУ-ын цөмийн цохилт өгөх социалист улсуудын тоонд Монгол Улс багтан Хятадын Ардын чөлөөлөх армийн хэдэн зуун мянган цэрэг Монголын өмнөд хилийн дагуу аюул заналхийлэл учруулж байсан юм. Г.Дэמיד жанжин тэртээ 1930-аад оны дундуур энэ аюулыг мэдэрч байжээ.

Г.Дэמיד БНМАУ-ын Зэвсэгт хүчин дайны үед дангаараа гаднын түрэмгийллийг няцаахад хүчин мөхөсдөх тул зайлшгүй Зөвлөлтийн цэргийн туслацааг авах нь зүйтэй ч дайны бус үед байнгын цэргийг байрлуулах нь итгэлцлийг эвдсэн үйл ажиллагаа болно гэж бодитоор дүгнэсэн байдаг. Ялангуяа 1935 онд эхэлсэн Монгол-Манжуурын хэлэлцээр үндсэндээ найрсаг уур амьсгалд харилцан ойлголцол дээр явагдаж байсан учир тэрээр дайны аюулыг хол гэж харан Зөвлөлтийн цэргийг байрлуулахын эсрэг санаагаа шууд хэлж байсан юм. Харин энэхүү санаа бодол нь их гүрэн ЗХУ-д таалагдаагүй бөгөөд гагцхүү түүний амь насны 1937 оны 8 дугаар сарын 22-ны өдөр хөнөөсний дараа Улаан армийн цэргүүд 1937 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс Монголд эрчимтэйгээр байрлах болсон билээ.

Г.Дэמיד МАХЦ-ийн боловсон хүчнийг бэхжүүлэн цэргийн чадварлаг удирдлагаар хангах асуудалд онцгой анхаарч ирсэн байдаг. Цэргийн боловсон хүчнийг Зөвлөлт Орос улсад болон дотооддоо бэлтгэхэд ихэд анхаарч боловсон хүчин харьцангуй сул байсан. Тиймээс Г.Дэמיד морьт-механикжуулсан цэргийг хослуулан тохиромжтой хэмээн үзэж байсан билээ. Цэргийн түүхч Д.Гомбосүрэн абугай "Дэмидийг механикжсан морьт цэргийн байгуулалтыг үндэслэгч" хэмээн нэгэнтээ хэлж байсан нь түүхэн үнэн юм. Мөн МАХЦ-ийг Европын янз маягийн байдал бүхий цэрэг болгох бодлогыг баримталж байсныг дурдах нь ч зүйтэй. Үүний үр дүнд МАХЦ-ийн даргалах бүрэлдэхүүний гол цөм нь Цэргийн ерөнхий сургууль болжээ. Үүгээр ч зогсохгүй 1933 онд Цэргийн ерөнхий сургуулийн дэргэд Академийн түр сургуулийг нээснээр Цэргийн яам, Жанжин штаб, хороо, дивиз, корпусын удирдлага зэрэг олон албан тушаалтан төгсжээ.

Г.Дэמיד мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг

бүрдүүлж, бэхжүүлэхэд онцгой анхаарч 1930-аад оноос албаа хааж дууссан цэрэг, бага дарга нардыг цэрэгт улираан алба хаалгах нь зүйтэй гэж үзсэн нь мэргэжлийн цэргийн үндэс суурийг тавиад зогсохгүй энэ тогтолцоо нь өнөөдөр улам боловсронгуй болж ахлагч бэлтгэх сургалтын тогтолцоо болон хувирчээ.

МАХЦ-ийн байлдааны бэлэн байдал, байлдах чадварыг дээшлүүлэх нэгэн алхам бол тухайн үеийн хэллэгээр "маневрын сургууль" буюу өнөө цагийн хэзэрийн сургууль юм. Энэ асуудлыг маршал Г.Дэמיד цэргийн сургалтын дээд хэлбэр гэж онцгойлон анхаарч ЗХУ-ын ижил түвшний сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, үр ашигтай талыг нь МАХЦ-т нэвтрүүлэх, хэзэрийн сургууль бүрийн дараа сургалтын үед гарсан ололт, дутагдал зэргийг шүүн ярилцаж, үүний дараагаар арга хэмжээ авдаг болжээ. Энэ уламжлал өнөөг хүртэл Монгол Улсын Зэвсэгт хүчинд үр өгөөжөө өгсөөр байна.

Маршал Г.Дэмидийн цэргийн нэрт зүтгэлтний хувьд хийж гүйцэтгэсэн гол ажлын нэг нь түүний шууд удирдлагаар явуулсан цэргийн ажиллагаанууд юм. Тухайлбал, 1932 оны зэвсэгт бослого, 1934 оны Хасагийн дээрэмчдийн эсрэг үйл ажиллагаа, 1936 оны дорнод хилийн дагуух хилийн мөргөлдөөнүүдийн үеэр явуулсан цэргийн ажиллагаа юм. Булан дэрс, Адаг дулаан гэдэг зүүн хилийн бүхий л мөргөлдөөнд Г.Дэмидийн удирдсан МАХЦ нь дайсны санаархлыг тас цохин эх орноо харийн түрэмгийлэгчдээс бат хамгаалсан билээ.

1932 оны зэвсэгт бослого нь түүхэнд ихээхэн маргаан, талцал, бослогыг хүчээр дарсан хэмээн ихээхэн шүүмжийг дагуулдаг. Гэвч маршал Г.Дэמיד нь төр, засгаас өгсөн үүргийг нэр төртэй биелүүлсэн юм. Баруун хилд Хасагийн дээрэмчдийн өдөөсөн хэрэг болон зүүн хилийн мөргөлдөөнд МАХЦ нь өөрт оногдсон үүргээ үнэнчээр биелүүлэн эх орноо харийн дайснаас өмгөөлөн хамгаалах ариун үүргээ нэр төртэй биелүүлсэн төдийгүй цэргийн гарамгай удирдагч Г.Дэмидийн нэр хүнд ард түмний дунд Зөвлөлтийн нэрт жанжин М.В.Фрунзе, С.М.Будённый адил домог болтлоо хүндлэгдэж ирсэн юм.

Цэл залуухан 36 насандаа БНМАУ-ын өрлөг жанжин (маршал) цолоор шагнагдана гэдэг хэн хүнд олдоод байхгүй эрхэм хүндтэй хүндэтгэл мөн. Гэвч ид хийж бүтээх асар их хүсэл мөрөөдөл, ажил үйлсийн үедээ буюу 37 насандаа амь насаа харамсалтайгаар алдсан юм.

Түүний жирэмсэн эхнэр, аав, ах гээд бүх ойр дотнын хүмүүсийг нь буудан хороож, "Гэндэн-Дэמיד"-ын эсэргүү бүлэг гэх зохиомол хэргээр гүтгэн доромжилж, харлан буруутгах харанхуй цаг үе ч байсан гашуун түүхтэй. Гэвч урин цагийн эрхээр маршал Г.Дэмидийн үйл хэрэг, алдар гавьяа, хэнд ч худалдагдаагүй ухаан бодол, оюун санааг олон түмэн ойлгон мэдэж авсан. Түүний хэлсэн ярьсан, хийж хэрэгжүүлсэн бүхэн өнөө цагийн Зэвсэгт хүчинд биеллээ олж хөрсөн дээр бат бэх соёолжээ.

Г.Дэמיד бол Монголоо гэх сэтгэлтэй, жинхэнэ эх оронч эр цэрэг, цэргийн чадварлаг жанжны нэг байжээ. Түүний хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дүнд 1930-аад оны БНМАУ-ын батлан хамгаалах хүчин батжин бэхжиж, орчин цагийн Зэвсэгт хүчинд шинэчлэл авчирч хэний ч өмнө нүүр улайхааргүй Зэвсэгт хүчинтэй болсон юм.

БНМАУ-ын анхны өрлөг жанжны (маршал) нэг Г.Дэмидийн МАХЦ-ийг бэхжүүлэх талаар хийж гүйцэтгэсэн ажил, гавьяа, зүтгэлийг хойч үе нь үргэлж санан дурсах болно.

АХМАД УЕ

Инженерийн цэргийн түүхэнд өөрийн нэрээ мөнхөлж, алдраа дурсгахын хамт өдгөө гаргасан амжилт, хийсэн бүтээсэн бүхнээрээ бахархал дүүрэн яваа хүний нэг нь чөлөөнд байгаа хурандаа Ядамжавын Цэнджав юм. 1960-аад оны эхээр Монголын Ардын Армийг өргөтгөн зохион байгуулах үед шинээр байгуулагдсан Инженер саперын тусгай ротын анхны захирагчаар томилогдож, хожим инженер саперын тусгай хорооны анхны захирагчаар ажиллаж байсан түүнийг нэгэн үеийн захирагч,

хүсэлт тавьснаар Амгалангийн орчим шинээр байгуулагдсан Инженер саперын тусгай ротын захирагчаар томилогджээ. Энэхүү тусгай рот нь 1965 онд Инженер саперын тусгай батальон болон зохион байгуулагдсан бөгөөд тэр үед дэслэгч Я.Цэнджав штабын даргын орлогчоор дэвшин ажилласан юм.

Тэр бээр 10 жилийн сургуулийг оройгоор төгсөж, боловсролын гэрчилгээг гардсан бөгөөд тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улсад цэргийн сургуульд суралцахаар “конкурс”-т өрсөлдөн

Тэрчлэн Налайх хотноо шинээр буурь сэлгэж, шилжин байрласан ангийнхаа гадна, дотно орчны тохижилтод онцгой анхаарч, их бүтээн байгуулалтыг өрнүүлсний дотор ангийн байрлалд инженерийн төхөөрөмжлөл бүхий сургалтын хотхонг шинээр байгуулж, байрлалын гадна инженерийн саад байгуулах, саадыг арилгах, инженерийн төхөөрөмжлөл хийх зориулалттай сургалтын талбайг дотоод бололцоогоо дайчлан байгуулсан ба өнөөдөр ч ашиглагдаж байгаа нь алсын хараатай ажил болсныг

хариуцлагатай ажлыг удирдах, тусгай бүлэг томилон ажиллуулах, шаардлагатай хангалтуудыг тасралтгүй зохион байгуулах, үүрэг гүйцэтгэлтийг нь биечлэн шалгах, үр дүнг тооцох зэрэг олон ажлын ард амжилт дүүрэн гарч байснаараа буурал хурандаа өдгөө ихэд бахархаж явна.

Нийтлэлийн баатрын маань хувьд 1976 он түүхэн жил байсныг тэр бээр хуучлах тун дуртай бөгөөд учир нь тэр жил Я.Цэнджав БХЯ-ны сайдын тушаалаар дэд хурандаа цол хүртэж, түүний удирдсан анги нь “Армийн тэргүүний хороо”-ны

доголдлыг арилгах талаар ихээхэн санаачилгатай ажилласнаар удалгүй Барилгын цэргийн 222 дугаар ангийн захирагчаар томилогдсон юм. Энэхүү анги нь Дорноговь аймгийн Сайншанд хотод байрлаж байсан бөгөөд тус аймгийн төвд мах боловсруулах үйлдвэр болон дулааны цахилгаан станцын барилгыг гүйцээж, ашиглалтад хүлээлгэн өгөх, аймгийн төвийн халаалтын системийг бүхэлд нь холбох ажлыг бүрэн дуусгах үйл хэрэгт ангийн захирагч, хурандаа Я.Цэнджавын үүрэг, оролцоо их байсан гэдэгт эргэлзэх юун билээ. Ингэж тавигдсан үүргээ үлгэр жишээ биелүүлсэн Барилгын цэргийн ангийг Улаанбаатар хотод шилжин байрлуулах, улмаар Барилгын цэргийн 017 дугаар ангитай нэгтгэх ажлыг тэр бээр чадварлаг зохион байгуулсан юм. Харин түүнийг 1988 онд дэд хурандаа С.Цэдэндамба өөрийнх нь анхлан байгуулсан төрөлх ангидаа хамтран ажиллахыг урьснаар Инженер саперын тусгай хорооны захирагчийн орлогчоор ажилласан юм. Энэхүү сонголт нь түүний алдар гавьяаны түүхэн замналтай тус ангиас гавьяаны амралтад гарах голч ухаан байсны илрэл бөгөөд ердөө нэг жилийн дараа тэрээр гавьяаныхаа амралтад гарсан юм.

Ийнхүү инженер саперын тусгай хороог байгуулах цагаас түүхийг нь дархлалцсан эрхэм хүмүүний нэг нь хурандаа Я.Цэнджав бөгөөд тэр бээр “Миний амжилт бүхэн чадварлаг дарга нарын ажилч хичээнгүй чанар, хамт олны маань итгэл, зүтгэл, ханийн минь түшиг” гэдгийг олонтоо онцолж байв. Я.Цэнджав 1973 онд Сүхбаатар аймгийн Хонгор сумын харьяат Лувсандоржийн Нинатай ханилж, найман хүүхэд төрүүлж, өсгөн эрүүл энх, аз жаргал дүүрэн, энх тунх амьдарч яваа бөгөөд эхнэр Л.Нина нь багшийн мэргэжлийг эзэмшиж, олон жил үр бүтээлтэй ажиллажээ.

Хурандаа Я.Цэнджав гавьяаныхаа амралтад гарсны дараа төрөлх ангийнхаа Ахмадын зөвлөлийн даргын үүрэгт ажлыг олон жил хийсэн бөгөөд ямартаа л түүнийг захирагч байхад нь хугацаат цэргийн алба хааж, хожим Ус хангалтын батальоны захирагчаар ажилласан бэлтгэл хошууч С.Сандаг “Олон жил Я.Цэнджав захирагчийн командад явлаа. Одоо нэг энэ захирагчийн мэдлээс мултарлаа гэсэн чинь бэлтгэлд гарангуутаа бас л

БАХАРХАМ ГАВЬЯАТАЙ БАХДАМ ХУРАНДАА



Хурандаа Я.Цэнджав дэслэгч генерал Л.Моломжамц, хурандаа С.Сайнцог нарын хамт

дарга нар, цэргийнхэн андахгүй гэхэд хилсдэхгүй. Учир нь удирдах албан тушаалтанд тавих шаардлага, шалгуур маш өндөр байсан жилүүдэд зөвхөн нэг ангийн захирагчаар 11 жил тогтвортой ажилласан түүний амжилтыг эвдсэн ангийн захирагч одоогоор алга байна.

Тэр бээр 1935 онд Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутагт төрсөн агаад сумынхаа бага сургуулийг дүүргэж, эрдэм номд хичээнгүйлэн суралцсаны буянд 1956 онд сумын Хувьсгалт залуучуудын эвлэлийн хорооны даргын сонгуульд ажлыг хүлээж, гурван жилийг ардаа орхижээ. Энэ хугацаанд үеийн нөхдийн хамтаар эр цэргийн албанд мордохоор саналаа өгсөн ч эвлэлийн хорооны даргыг явуулахгүй гэж хориг тавьдаг байсан юм. Харин БХЯ-ны Авто, хуягт танкийн хэлтсийн дарга, Монгол Улсын гавьяат тээвэрчин, хурандаа Батын Намхай цэрэг татлагын комиссоор очиж, “Өөрийн саналаараа явах гэж байгаа тул цэрэгт мордуулна” гэснээр түүний хүсэл биелсэн хэрэг. Ингэснээр тухайн үед Улаанхуаранд байрлаж байсан Инженер саперын тусгай ротод хугацаат цэргийн алба хааж эхэлсэн бөгөөд жирийн нэг байлдагчаас хурандаа болох ирээдүйн зам нь шуударсан аж. Я.Цэнджав тухайн үедээ намын гишүүн байсан бөгөөд тусгай ротын намын гишүүдийн хуралд суудаг маадгар цэрэг байсан болохоор ротын улс төрийн орлогч, ахлах дэслэгч Билэгтийн Банзрагч нэг удаа “Залуу намын гишүүн шүүмжлэл тавиаарай” гэж үүрэгджээ. Энэ үед байлдагч Я.Цэнджав “Шинээр ашиглалтад орох гэж байгаа 36 айлын орон сууцны гадна талбайд ажиллахаар яваа цэргийн алба хаагчдыг байнга галуун цуваагаар суулган явуулж байгаа нь эрүүл мэндэд их хортойгоос гадна бага дарга нар эрх мэдлээ хэтрүүлэн цэрэг дэглэж байна” хэмээн нэлээн ширүүн шүүмжлэлийг тавьсан ажээ.

Ингэснээр дарга нарыг шүүмжилдэг айтхар цэргийн тоонд орж, “өөрийн биеэр үлгэрлэ” гэдэг үүрэг өгөгдөж, удалгүй ротын жагсаалын даргаар дэвшин томилогджээ. Тэр бээр 1961 онд бага дэслэгч цол хүртэж, салааны захирагчаар дэвшин томилогдсоноор инженерийн цэрэгтэй өөрийн ажил, амьдралаа холбосон хэрэг. Шинэхэн салааны захирагч түүнд хичээлийн конспект бичиж, салааны дайчидтай онолын болон дадлагын сургалтыг явуулах, цэргийн алба, ахуй хангалтыг нь зохион байгуулах, үндсэн ажлынхаа хажуугаар 10 жилийн боловсрол олгох сургалтад хамрагдах гээд унтах завгүй шахам байсан нь ойлгомжтой биз. Нийтлэлийн баатар маань 1962 онд Офицеруудын мэргэжил дээшлүүлэх төвд 6 сарын хугацаатай суралцаж, цэргийн хэргийн дадлага, үр чадвараа ахиулсан бөгөөд тухайн үед АЦХЭЯ-ны Инженерийн хэлтсийн дарга, дэд хурандаа Ламаяхүү

тэнцсэнээр В.В.Куйбышевийн нэрэмжит Цэргийн инженерийн академид суралцах ховорхон боломж, их хувь заяа түүнд олджээ. Ахлах дэслэгч цолоо гардаж, академи явах болзлоо хангасан түүнийг наадам үзэх зуур 1966 оны аймшигт үер болж, Богд хан уулаас Улаанхуаран хүртэл үргэлжилсэн ихээхэн хэмжээний үерийн ус тогтож, хүн ам, эд баялагт ноцтой хохирол учирсан ба үерийн голомтоос хүн ардыг авран хамгаалах, түүний хор уршгийг арилгах талаар олон хоног нойр, хоолгүй зүтгэн өөрийн хувь нэмрээ оруулжээ. Энэхүү нэн хариуцлагатай ажилд өөрийн хамт олныг сайн удирдан оролцсон Я.Цэнджавыг Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар “Шударга журам” медалиар шагнасан нь түүний хөдөлмөр, зүтгэлийн тод илрэл төдийгүй энгэрт нь гялалзах хамгийн хүндтэй шагналынх нэг байлаа. Я.Цэнджав Цэргийн инженерийн академийг, хожим инженерийн цэргийн дарга болсон хурандаа Л.Өлзийбат, УБХТН-ийн дарга асан, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, хурандаа С.Сайнцог нарын хамт 1972 онд амжилттай төгссөн бөгөөд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид штабын даргын хариуцлагатай албанд дэвшин томилогдсон юм. Тухайн үеийн шинэхэн штабын дарга тэр бээр ангийн байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүлэх, гэмт хэрэг, сахилгын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, бие бүрэлдэхүүний үр чадвар болоод цэргийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх талаар ихээхэн анхаарал хандуулж, ажилтад хүрсэн юм.

Үүний үр дүнд Я.Цэнджав ердөө нэг жилийн дараа ангийн захирагчийн нэр хүндтэй бөгөөд өндөр хариуцлагатай албанд дэвшин томилогдож, энэ албан тушаалд 11 жил тогтвортой ажиллажээ. Энэ үед ангийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, зэвсэглэл, техникийн бэлэн байдлыг дээшлүүлэх, сургалт, соёл хүмүүжлийн ажлын нэгдлийг хангах, армийн хэмжээнд явагдах бүхий л уралдаан, тэмцээнд амжилт гаргаж оролцох, ар тал, ахуй хангалтыг сайжруулах, байнгын бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх гээд ямархан их цар хүрээтэй ажлыг үлгэр жишээчээр зохион байгуулж ирснийг илтгэх олон арван баримт түүхийн хуудаснаа үлдэж, өнөөдөр тэрхүү амжилтыг нь бахархан магтах хүн олон юм билээ. Мөн инженерийн төрөл бүрийн машинд зориулсан тусгай тавиулан, автогражтай болох асуудлыг бүрэн шийдвэрлэж, томилгоот алба хаагч нэг бүрийг хариуцсан техниктээ эзэн нь болж, ямар нэгэн осол, зөрчилгүй үүрэг гүйцэтгэх чадвар эзэмшүүлэхийн зэрэгцээ зарим техник дээр нэгнийгээ орлон ажиллах дадлагатай болгоход анхаарч ирсэн нь түүний амжилтын нэг үндэс байлаа.

гэрчлэх бөлгөө.

Түүнийг ангийн захирагчаар ажиллах хугацаанд 1976 онд Ардын Армийн тэргүүний ангийн болзлыг хангаснаас хойш хоёр жил тутам явагддаг БХЯ-ны сайдын нэрэмжит иж бүрэн шалгалтын дүнгээр тэргүүний ангийн нэр алдрыг таван удаа бататгаж ирсэн нь түүний удирдах арга барил, нөр их хөдөлмөрийн үр дүн, захирагч, орлогч нарын гар нийлэмжтэй ажиллагаа, нийт бие бүрэлдэхүүний бүтээлч ажлын тод илрэл болж байсныг тус ангийн түүх бэлхнээ гэрчилж байна.

Хошууч Я.Цэнджавыг ангийн захирагчаар томилогдсон жил алдарт “Хэрлэн-73” хэргийн сургууль болж, энэхүү сургалтын явцад Армийн командын үндсэн болон бэлтгэл байрыг төхөөрөмжлөх, инженерийн саад байгуулах, сааданд гарц гаргах, усны хангалтыг зохион байгуулах зэрэг үүргийг үлгэр жишээ биелүүлж чадсан бөгөөд тэр үеэс хойш явагдсан бүхий л хэргийн сургууль, команд штабын сургуульд тавигдсан үүргийг чадамгай биелүүлж оролцсон нь тус ангийн бахархах үйлсийн нэг болохыг би бээр сайтар мэдэх юм. Түүнчлэн Налайх хотын захиргаа, орон нутгийн байгууллагуудтай

болзлыг хангасан зэргээр амжилт дүүрэн байжээ. Түүнчлэн тэр жил эрхэм захирагч маань ард түмнийхээ итгэлийг дааж Ардын Их Хурлын депутатаар сонгогдсон түүхэн үйл явдал нь түүний арвин их амжилт, баялаг түүхийг улам бүр тодотгох ажээ. Энэхүү нэр хүндтэй сонгуульд манлайлан гэж огт санаанд нь багтаагүй явсан гэдэг бөгөөд тухайн үеийн Ардын Армийн Улс төрийн газрын дарга, дэслэгч генерал Д.Ёндондүйчир тэргүүтэй ажлын хэсгийнхэн түүний захирсан ангид гурвантаа ирж, шалгасан түүх бас л сонирхол татна. Учир нь, дэслэгч генерал Д.Ёндондүйчирийн удирдсан ажлын хэсэг эхний удаа өглөөний босолт, үйл ажиллагааг, дараагийнхад нь шөнийн амралт, харуул, хоногийн манааны бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлтийг, төрсгөлд нь ангийн өдөр тутмын үйл ажиллагаа, сургалт, соёл хүмүүжлийн ажлын явц, хоолны амт чанар, боловсруулалтыг шалгаж, “Аргагүй л тэргүүний анги юм даа” хэмээн магтсан байдаг. Ингэснээр Ардын Их Хуралд нийгмийн давхарга бүрийн төлөөлөл орж байсан тухайн үед Армийн онц анги болсон Ардын Армийн 028 дугаар ангийн захирагч, хурандаа Ч.Пүрэвдоржийн дараагаар депутатаар сонгогдсон түүхэн



Зүүн гар талаас: Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагчаар ажиллаж байсан хурандаа Б.Отгонпүрэв, С.Дондогдорж, бригадын генерал П.Доржсүрэн, хурандаа Я.Цэнджав, дэд хурандаа С.Цэдэндамба, хурандаа Г.Батсүрэн

нягт хамтран ажиллаж, иргэдэд Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, хотын хөгжилтөд ангийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх талаар ихээхэн санаачилгатай ажилласан нь хотын депутатаар сонгогдож, үр дүнтэй ажилласнаар мэдрэгдэж байна.

Түүний удирдсан инженер саперын ангийн өөр нэг чухал үүрэг нь эх орныхоо хөгжил, дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулснаар тодорхойлогдох ба Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь аймгуудад усны хайгуул хийж, худаг гаргах, зудад нэрвэгдсэн аймаг, сумдад цувааны зам гаргах, хүн, машиныг цуваагаар явах нөхцөлийг хангах үүргийг нэр төртэй гүйцэтгэж ирснийг аймаг, орон нутгийн удирдлага, иргэд ямагт өндөр үнэлж байдаг юм. Тэрчлэн Дорнод аймгийн Халхын голын районд тариалангийн талбайг шинээр байгуулах ажилд дэмжлэг үзүүлж, дайны дараах тэсэрч, дэлбэрээгүй сум, галт хэрэглэлийг илрүүлж, устгах, аюулгүй болгох үүргийг тус анги хүлээж, тэрхүү

хүн нь дэд хурандаа Я.Цэнджав байсан юм. 1978 онд тус анги дахин Армийн тэргүүний ангийн болзлыг хангасан бөгөөд энэхүү ажлын үр дүнгээр Инженер саперын тусгай хорооны захирагчийн орлогч, дэд хурандаа Ж.Чимэд, улс төрийн орлогч, дэд хурандаа Б.Санжаа нар Сүхбаатарын одон хүртсэн нь “нэг ангиас хоёулаа нэг дор” гэдгээрээ содон бөгөөд түүнд эрхэм хурандаа ихэд баярлаж, бахдаж явдгаа илэрхийлж билээ. Харин түүний дараа жил Я.Цэнджав захирагч БХЯ-ны сайдын тушаалаар “Хурандаа” хэмээх эрхэм цол хүртэж, байлдагч, бага дэслэгчийн халаасанд хурандаагийн мөрдэс байдаг гэдгийг жинхэнэ утгаар нь харуулж, үе тэнгийн офицерууд, ангийн хамт олон, хань, үр хүүхдийнхээ бахархал нь болж гэрэлтсэн юм.

Хурандаа Я.Цэнджав 1984 онд Барилгын цэргийг удирдах газрын чанарын албанд ажиллах болж, аливаа нэгэн санал, гомдол гарсан барилгын ажлын явцыг шалган туслах, зарим барилга, объектод гарсан

удирдлагад нь ирчихлээ” гээд хошигнож суух вэ дээ.

Эрхэм хурандаа маань тус ангийн Ахмадын зөвлөлийн даргаар ажиллахдаа мэргэжлийн уралдаан, тэмцээнийг явуулж, ахмадуудтай дурсамж уулзалтуудыг зохион байгуулах, тэдний хөдөлмөрийн алдрыг тэмдэглэх зэрэг олон бүтээлт ажлын эхлэлийг тавьсны дотор 1990-ээд оноос жил бүрийн 7 дугаар сард инженерийн анги, салбаруудад ажиллаж байсан ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлдэг ажил нь аль ч захирагчийн үед хэрэгждэг уламжлалт арга хэмжээ болсонд бид бахархалтай ханддаг билээ.

Инженерийн цэргийн түүхийг бичилцсэн эрхэм хурандаа Я.Цэнджав захирагч маань үнэхээр л бахархам гавьяатай, бахдам амжилттай буурал хурандаа болохыг гэрчилсэн энэхүү нийтлэлээ бичиж, уншигч тантай саналаа хуваалцахыг зорьсон нь энэ билээ.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

МЭРГЭЖЛЭЭРЭЭ “ӨВЧИЛСӨН” ЭРХЭМ

Монгол Улсад нисэх хүчнээс төрсөн генерал цөөн байдаг. Тэдний нэг нь бригадын генерал Б.Батбаяр юм. Түүнийг хэдхэн хоногийн өмнө Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын штабын дарга гэдгээс нь өөрөөр буюу хоббигоор нь мэддэг болсон билээ. Бригадын генерал Б.Батбаяр мэргэжлээрээ “өвчилсөн” хүн болоод ч тэр үү, сөнөөгч онгоц, амдан сөнөөгч онгоц, иргэний тээврийн болон нисдэг тэрэг, бөмбөгдөгч онгоц, сансрын хөлөг зэргийн загварыг цуглуулаад 16

гэдгийг ч учирласан. Одоогоор түүний цуглуулга дахь онгоцны моделийн тоо 100 давсан. Ажил, мэргэжлээсээ гадна сонирхол, хоббигоороо хэдийнээ Зэвсэгт хүчиндээ өчнээ танил болсон тул журмын нөхөд, гаднын орнуудаар яваад ирсэн мэргэжил нэгтгүүд нь ч сайн дураараа цуглуулгыг нь арвижуулахад тусалдаг байна.

Тэдгээрийн дотроос онцолбол, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал О.Энхбаяр гэхэд л хэд хэдэн чухал моделийг бэлэглэжээ.

километр цагийн хурдтай, зэвсэглэл сайтай. Оросууд баратгаа модель байдлаар хийдэггүй байж. Сүүлд тэр бээр ОХУ-д очихдоо барааг нь харсан даруйдаа “чаргууцалдсаар” байж цуглуулгадаа залж чадсан гэнэ. Тодруулбал, улс орнуудын нисэх хүчний үзэсгэлэн дэглэгдэх үеэр Жуковскийн нэрэмжит академийг хамт төгссөн нөхөртэйгөө таарч танилын нүүр халуун гэгч нь болж хүүсэндээ хүрсэн нь энэ. Түүнээс хамгийн сонирхолтой байдлаар гарт нь очсон цуглуулгын талаар асуухад нэг их



жилийн нүүрийг үзэж байгаа аж.

Ажил, мэргэжлээс нь үүдсэн цуглуулгын нь түүх хэзээ, хэрхэн эхэлсэнтэй танилцъя. Тэрээр 2004 онд Канад улсад ажлаар очихдоо нэгэн цэргийн музейг үзэж сонирхжээ. Тэнд анхаарал татахуйц сонин, содон гэмээр олон төрлийн зүйл байсан ч мэргэжлийн онцлогтоо хөтөлгөн шууд онгоцны хэсгээр зочилтол “F-15” загварын онгоцоор дүрсэлсэн харандаа үзүүрлэгч нь түүний сонирхлыг ихэд татсан учраас худалдаж аваад нутаг буцсан байна. Эхэндээ ажлын ширээн дээрээ зүгээр л үзүүлэн болгож тавьдаг байсан ч цаашдаа ажил албаны шугамаар гаднын орнуудаар зорчих бүртээ цуглуулгынхаа тоог нэмэх болжээ. Түүний онгоц цуглуулах хобби ингэж эхэлсэн түүхтэй. Цуглуулгаа арвижуулахдаа яг л ажил албандаа ханддаг шиг сэтгэлээ зориулж, тууштай эрэлхийлдгийн хүчинд эхний жилүүдэд л хүнд сонирхуулахуйц олон үзэмртэй болжээ.

Тэрээр “Цуглуулгаа ердийн гэж хэлэх аргагүй. Учир нь тухайн орон бол өөрсдийнх нь зохион бүтээсэн онгоц, нисдэг тэрэгний 100, 200 дахин багасгасан загвар буюу модель нь музей, үйлчилгээний төвүүдээр худалдаалагддаг. Төмөр, мод, хүрэл гээд төрөл бүрийн материалаар дуурайлгаж хийсэн онгоцнуудтай таарч байлаа. Надад таалагдсан л бол авах гээд гүрийчихдэг. Санхүүгийн бололцоотой бол гар татаад байх зүйлгүй. Миний цуглуулгад сөнөөгч онгоцнууд зонхилдог” гэв. Түүний цуглуулгад байгаа онгоцнуудыг зарим нэр төрлөөр нь интернэтээс хайлт хийж үзлээ. Яг дүрээрээ байх нь тэр. Моделиуд нь яг л “өвчсөн” юм шиг адилхан гэж яана. Тухайн улсад нь очоод үзэхийг хүссэн хэн бүхэн түүний цуглуулгаас хангалттай мэдээлэл авч болохоор санагдсан. Учир нь загвар бүр өмнөө нэр, үүрэг, зориулалт, хүчин чадал гэх мэт тайлбартайгаа байдаг аж. Энэ нь түүнийг ажил, мэргэжилдээ ч нэвтэрхий толь шиг хүн гэдгийг хэлээд өгнө. Анхандаа цуглуулгаа гэртээ хадгалдаг байсан бол хоёр оронтой тоонд хүрэхээр нь ажлынхаа өрөөнд авчирч олон тасалгаатай, хоёр метр бүхий өндөр шилэн хоргонд байлгах болжээ. Түүний өрөөгөөр орж, гарсан хэн ч

Мөн БНХАУ-ын Пионер, сурагчдын дугуйлангийн хүүхдүүдийн цул төмрөөр гагнаж урласан иргэний тээврийн онгоц нэн сонирхолтой. Анзаарч харвал хошуу нь их биеэсээ ялимгүй дээш өндөрт өргөгдсөн нь агаарт дөнгөж хөөрч буйг нь илтгэх агаад “Нисгэгчийн дуу”-нд гардаг суман цагаан хөлгийг өөрийн эрхгүй санагдуулна. Дараа нь цул ялтсаар бүрсэн “Z-10” гэх их чамин хийцтэй онгоцыг онцолж болно. Мөн та бидний өвөө, эмээ л цөөн харсан, дэлхийн хоёрдугаар дайны үед агаарын тулалдаанд үнэн хүчийг үзүүлж байсан гэлцдэг “Як” хэмээх онгоцны резинэн хувилбар. Модоор сийлсэн, цаасаар урласан, шилэн гээд байж болох бүхий л материалаар хийгдсэн эдгээр гоёмсог үзмэрүүдийг хэдэнтээ харсан ч сонирхол буурахгүйгээр барам нүдээ ахин дахин хужирлаад л баймаар санагдана. Түүнчлэн онгоцнуудаа үзүүлэлтээр нь нэгээс тавдугаар үе хүртэл эрэмбэлжээ. Тавдугаар буюу хамгийн сүүлийн үед зохион бүтээгдсэн онгоцнууд нь бодит амьдрал дээр тулалдах чадвар, үзүүлэлтээрээ бусдаасаа харьцангуй илүү ажээ. Эдгээр онгоцон дунд сансрын хөлөг болоод сансрын тээвэрлэгч онгоц ч мэр сэр үзэгдэнэ. Тухайлбал, эхэнд дурдагдсан “харандаа үзүүрлэгч” нь “Спутник” загварын сансрын хөлөг болсон байх жишээтэй. Түүний хамгийн сүүлд нэмсэн загвар нь хоёр сарын өмнө эгнээндээ нэгтгэсэн “F-35” загварын байлдааны онгоц. Тавдугаар үеийнхэн дундаа бас л цойлохоор үзүүлэлттэй. Дашрамд бригадын генерал Б.Батбаяр “F-35”, “Су-57”, “Су-37” зэрэг онгоцны яндан нь эгц доош чиглэсэн байх ба энэ нь хөдөлгөөн үйлдэлгүй агаарт удаан хугацаагаар тогтоход зориулагдсан байдаг талаар сонирхолтой мэдээллийг хүргэж билээ.

Нэгдүгээр үеэс манай улсын иргэний агаарын тээврийн онгоцны цөөнгүй загвар ч бий. Тухайлбал, Боинг-737, Боинг-800, Боинг-777, Боинг-767-300, Боинг-737МАХ зэрэг. Онгоцны хэлбэр, төрхөд оруулсан цаасны хавчаар хүртэл хэд хэд байв. Бригадын генерал Б.Батбаярыг өөрөө ингэж “элдэвлээд” сурчихсан юм болов уу ч гэж бодоод асуутал, үгүй гэнэ. Зарим цуглуулга нь онгоц

саатаж, бодолхийлсэнгүй. Яг ийм асуулт ирэх байх гээд анаж байлаа гээд гуравдугаар үед хамаарах нэгэн онгоцыг танилцуулсан. Люксембург улсад очих үедээ худалдаж авсан бөгөөд машины “севч”-гээр хийсэн байна. Итгэмээргүй сонин, цор ганц загвар байсан тул хошуураад л авчихсан гэнэ. Монголдоо цор ганц гэж хэлж болох цуглуулгынхаа тоог сүүлийн хоёр сар гаруйн хугацаанд нэмж, хасаагүй. Тэрээр шинэ загварын байлдааны онгоц үйлдвэрлэгдэх мөчийг хүлээж сууна. Гэхдээ зохион бүтээгдсэнээс хойш урт хугацааны дараагаар модель нь иргэдийн гарт хүрдэг тул их л хүлээцтэй чанарыг шаарддаг. Харин бригадын генерал Б.Батбаяр энэ чанарт сайн дадсан учир цуглуулгаа гурван оронтой тоонд хүргээд байгаа гэдгийг хэлэх нь зүйн хэрэг юм. Бидний ярианы сэдэв хоббигоос салж өөр зүгт чиглэх үед түүнийг спортод ч авьяастай хүн болохыг нь мэдсэн. Тэрээр “Залуугаасаа сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг зэрэг спортоор идэвхтэй хичээллэсэн. Гэхдээ хөл бөмбөгийн спортоороо дагнаж байгаа. Ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээний хэд хэдэн медальтай” гэлээ. Энэхүү яриаг нотлох гэсэн шиг энгэр дээрх “Спортын мастер” гэсэн тэмдэг нь гялтганан хэдийнээ нүдэнд өртөөд амжив. Мөн урлагийнхны талаар амттай яриа өрнүүлсэн ч бүгдийг энд өгүүлнэ гэвэл сонин зай талбай багадаа таарна. Ямартаа ч 30 гаруй жилийн турш “Хурд” хамтлагийн уран бүтээлүүдийг алгасалгүй сонсож байгаа үнэнч шүтэн бишрэгч нь бөгөөд тэдний “Цэргийн бодол” “Аавдаа би хайртай” зэрэг уран бүтээлд тун дуртайгаас гадна утга, санааг нь ойлгож, гүн мэдэрдэг ажээ. “Бусад хүнээс арай гүнзгий түвшинд хүлээж авдаг гэхэд хилсдэхгүй. Жишээлбэл, “Аавдаа би хайртай” дуу.

“Намрын бороо зөөлөн шиврэхэд аав минь даанч дуртай Насыг нь зөөж буцсаар байгаа шувуудад хайртай Өөрөө өтлөвч орчлонд үлдэнэ гэж наддаа хайртай Өдрөөс өдөрт холдсоор байгаа аавдаа би хайртай” гээд яг л загатнасан газар маажих шиг болдог, яаж ингэж донжийг нь, голыг нь гайхалтай олж бичсэн юм бол.



цуглуулгыг нь хараад л уягдаж, саатах нь дамжиггүй.

“Цуглуулга нэмэгдэхийн хэрээр багтааж, шингээх зай, талбай улам л хомсдоод байсан учир ажлын өрөөндөө авчирсан. Сүүлийн үед өнөөх шилэн хорго маань ч хадгалах үүргээ гүйцэтгэж чадахаа байлаа” гэж тэрээр хөнгөн инээд алдаад үргэлжлүүлэн дан ганц өөрийн хичээл зүтгэлээр ийм арвин болчоогүй



гэхээсээ илүүтэй гоёмсог, чамин бэлэг, дурсгалын зүйлс шиг санагдана.

Ажлын өрөөнийг нь ханыг дагуулаад харвал түүний сонирхол, цуглуулга нь зурган хэлбэрт хэдийн хөрвөжээ. Хамгийн ихээр хөөцөлдөж, эрэл сурал болсон онгоц нь “МиГ-35” буюу амдан сөнөөгч. Нэрнээсээ л танд үүрэг, зориулалт нь ойлгогдон байх. Эсрэг талын онгоцыг отож, амдах байдлаар угаж сөнөөдөг. 2500



Цэргийн хуарангаас төрсөн “Цэргийн бодол” дуу ч мөн адил, ер нь алба хааж буй хүнийг их л гэгэлзүүлдэг юм билээ” гэв. Түүний хамгийн ихээр хэлэх дуртай үг нь “Доуарьят можно, проверять нужно”. Энэ нь “Итгэж болно, гэхдээ шалгах хэрэгтэй” гэсэн утгатай аж. Эрхэм генералын хоббигоор аялсан тэмдэглэл ийнхүү өндөрлөж байна.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

Би цэргийн гэрээт алба хаагч

МИНИЙ ЗОРИЛГО ТОДОРХОЙ, ЭНЭ БОЛ “ЦЭРЭГ”

Уншигчдад өөрийгөө товч танилцуулна уу?

–Намайг З.Хишигт гэдэг. 1995 онд Ховд аймгийн Жаргалант сумын нутагт төрсөн. Ам бүл долуулаа, аав, ээж, дүү нарын хамт амьдардаг. Ховд аймгийн “Цаст-Алтай” цогцолбор сургуулийг төгссөн.

Хугацаат цэргийн албыг хаана хаасан бэ?

–2015 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар Хилийн цэргийн 0165 дугаар ангид ирж, алба хаасан. 2019 оны 3 дугаар сараас Зэвсэгт хүчний 123 дугаар ангид цэргийн гэрээт албыг хааж байна.

Цэргийн гэрээт албыг сонгох болсон шалтгаан юу вэ?

–Миний ах, дүү, хамаатан саданд Зэвсэгт хүчинд ажилладаг хүмүүс цөөнгүй бий. Хүүхэд байхаасаа л тэднийг харж үлгэр дуурайл авч өссөн болохоор цашид цэргийн хүн болж, эх орондоо зүтгэнэ хэмээн шийдэн албаа хааж байна даа.

Өөрийг тань таеквондогийн спортоор хичээллэдэг, багагүй амжилт гаргасан гэж сонссон ...

–Анх 2007 оноос Ховд аймгийн “Эрин” клубт хичээллэж эхэлсэн. Таеквондогийн спорт нь хүнд тэсвэр хатуужил, эр зориг, зөв боловсон харилцааг төлөвшүүлдэг. 2019 онд Баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс алт,

Бас 2019 оны шилдэг цэргийн гэрээт алба хаагчаар шалгарсан. Багагүй амжилт шүү ...

–Зорилго минь бага ч гэсэн биелж байна. Аливаа бүхнийг зааж сургасан ангийн захирагч, удирдлага, салбар, салааны захирагч нартаа баярлалаа гэж энэ дашрамд хэлье.

Цэргийн албанд ирсэн анхны сэтгэгдлээ хуваалцахгүй юу?

–Цэргийн албаны талаар анхан шатны мэдэгдэхүүнтэй байсан боловч яг биеэр туулаад ирэхээр бас л яггүй алба шүү. “Гараад жагс” командаар бүгд гүйлдээд гарсан. Харин би багадсан гуталтайгаа ноцолдоод үлдэж байсан хөгтэй явдал бий.

Цэргийн алба хаасны давуу тал нь юу вэ?

–Маш олон давуу талтай. Бие бялдрын хөгжил, сэтгэл зүйн хувьд тэсвэр хатуужилтай болж, хүнтэй харилцах харилцааны ур чадварт суралцаж байна. Цэргийн гэрээт алба хаагчдын алба хаах орчин, нөхцөл, боломж өдрөөс өдөрт сайжирч, цалин нэмэгдсэнд баяртай байгаа.

Цаашдын зорилго ...

–Монгол Улсын Зэвсэгт хүчний ахлагчийн албанд элсэх, өөрийн эх орныхоо нэр хүндийг дэлхий дахинд дуурсгаж буй энхийг



Ерөнхийлөгчийн цомын тэмцээнээс хүрэл, Баруун бүсийн таеквондогийн клубүүдийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медальгүй тус тус хүртсэн амжилтыг үзүүлж байлаа.

сахиулагчидтайгаа мөр зэргэцэн үүрэг гүйцэтгэж, цэргийн эрдэмд улам илүү шамдан суралцахыг л гол зорилго болгон хичээж явна. Танд амжилт хүсье.

Монгол цэргийн музейн сан хөмрөгөөс ...

ХОТГОР ИЛД



Монгол цэргийн музей нь сан хөмрөгтөө хадгалагдаж байгаа үзмэрийн дээжээс Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгал болох “Хотгор илд”-ийг онцлон танилцуулж байна. Дундад зууны үед монгол цэргүүдийн хэрэглэж байсан олон төрлийн илдийн дотроос металлын бүтэц, археологийн судалгаа, шинжилгээ хийгдсэн монгол хийцийн илд нь энэхүү Хотгор илд юм.

Хотгор илд нь хурц үзүүртэй, цавчихад нэг их хүч шаардахгүйгээр далайсан хүчээр үзүүр хүртэл зүсэн өнгөрдөг онцлогтой охор зэвсэг юм. Охор зэвсэг гэдэг нь байлдан тулалдах явцад гараас салгалгүйгээр хатгалдан цавчилдах зориулалттай илд, жад, хутга, бялуу, сүх тэргүүтнийг хэлдэг. Илдийн хөнгөн, хурц иртэй байгаа нь төмрийн хатаалт сайтайг илтгэдэг. Монгол дархчууд илдийг салхин, давс хүчлийн, эвэр туурайн, зунгаг үс ноосны гэх мэт олон төрлийн аргаар давтаж маш даацтай, хурц илд хийдэг байжээ.

Монгол цэргийн музейн хосгүй үнэт үзмэр болох Хотгор илдийг 1984 онд Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутгаас Ардын цэргийн 065 дугаар ангийн салбарын улс төрийн орлогч Н.Базаррагчаа олж, музейд өгчээ. Илдийн металлын бүтцийн судалгааг доктор П.Баясгалан хийж, дундад зууны үед хамаарах болохыг нь тогтоосон байдаг.

Хотгор илдийн урт нь 80,7, өргөн нь 3,7 сантиметр, жин нь 800 грамм бөгөөд бариулаас доош илдийн угт урт нь 8,1, өргөн нь 1,6 сантиметр бөгөөд давхиж байгаагаар чонын дүрсийг хоёр талд нь бодит бус байдлаар загварчлан, уран чадварлагаар товойлгон сийлсэн байдаг. Энэ нь монголчуудын чоныг хийморь сүлдтэй амьтан хэмээн эрхэмлэн дээдэлж ирсэн эртний уламжлалтай холбоотой. Энэхүү Хотгор илд нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 227 дугаар тогтоолоор Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалар бүртгэгдсэн юм. Түүнчлэн эртний монгол цэргийн зэр зэвсгийн хөгжлийг төлөөлөн үзүүлж чадсанаараа онцлогтой бөгөөд Монгол Улсад төдийгүй АНУ, Герман, Солонгос, Австрали зэрэг гадаадын олон оронд зохиогдсон үзэсгэлэнд тавигдаж, дэлхийн үзэгч, судлаачдын сонирхлыг татсан үзмэр юм.

Боловсролын ажилтан-тайлбарлагч Д.БАЯНЖАРГАЛ



СОЁМБО СОНИН

“Соёмбо” сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг “Соёмбо” сонин
редакцад бэлтгэж,
“Соёмбо принтинг” хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламгыг хямд нийтэлнэ.
*Зар, рекламны үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018

И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029